

КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ТАЙЛАН **2013**



КОМПАНИЙН ТУХАЙ	
Товч танилцуулга	06
Компанийн засаглал	07
2013 оны онцлох үйл явдал, бүтээн байгуулалт	07
КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА	09
Компанийн нийгмийн хариуцлагын удирдлага	09
КНХ-ын бодлого, чиг баримжаа	09
Оролцогч, сонирхогч талуудын хамтын ажиллагаа	10
Өргөдөл, гомдол барагдуулах механизм	11
АЖЛЫН БАЙР, ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦАА	12
Хүний нөөцийн удирдлага	12
Ажлын байр, тэгш боломж	12
Ажиллагсдын шилжилт хөдөлгөөн	13
Сургалт, хөгжил	14
Ажиллагсдын нийгмийн халамж, хамгаалал	14
ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛД ОРУУЛЖ БУЙ ХУВЬ НЭМЭР	15
Татвар төлөлт	15
Орон нутгийн хөрөнгө оруулалт	15
Орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжих төсөл, хөтөлбөрүүд	15
БАЙГАЛЬ ОРЧИН, ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ (БОХАБЭА)	19
БОХАБЭА-н удирдлага	19
Байгаль орчны бодлого, чиг баримжаа	19
Байгаль орчны суурь судалгаа	20
Газар ашиглалт, нөхөн сэргээлт	20
Биологийн төрөл зүйлийг дэмжих	21
Хог хаягдлын менежмент	22
Усны зохистой хэрэглээ	23
Агаарын чанар, тоосжилт	24
Байгаль орчны хяналт, үнэлгээ	25
Хөдөлмөрийн аюулгүй байдал (ХАБ)-ын бодлого чиг, баримжаа	25
ХАБ-ын гол үзүүлэлтүүд	26
ХАБ-ын сургалт, зааварчилгаа	26
Ажиллагсдын эрүүл мэнд	27
ТҮҮХЭН ТОВЧООН	28
БИДНИЙ АМЖИЛТ, ҮР ДҮН	29







ЭРХЭМ ЗОРИЛГО

Бид орчин үеийн техник, технологийг мэргэшсэн боловсон хүчний ур чадвар, хүсэл тэмүүлэлтэй хослуулан Монгол улсын хөгжил, эдийн засгийн өсөлтөнд хувь нэмрээ оруулна.

АЛСЫН ХАРАА

Бид олон улсын зах зээл дээр нүүрс, нүүрсэн бүтээгдэхүүн борлуулах дэлхийн хэмжээний үйл ажиллагаатай үйлдвэрлэгч компани болно.

ҮНЭТ ЗҮЙЛС

Ажиллагсад, боловсон хүчин манай компанийн амин чухал зүйл гэж бид үздэг, Иймд:

- Энержи Ресурс ХХК нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчинг нэн тэргүүнд анхаарна.
- Энержи Ресурс ХХК нь ур чадвар, ажлын үр дүнг харгалзсан хөдөлмөр эрхлэлтийн адил тэгш боломжоор хангаж хариуцлагатай ажил олгогч байна.

Орчин үеийн өндөр үр өгөөжтэй техник технологи нь Монголд хөгжил дэвшил авчирна гэдэгт бид итгэдэг, Иймд:

- Энержи Ресурс ХХК нь сайн чанарын бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг дэлхийн түвшний нүүрсний уурхай байгуулж хөгжүүлнэ.
- Энержи Ресурс ХХК нь Монгол Улсын нүүрс олборлолтын салбарт техникийн шинэ стандарт тогтоохыг зорино.

Бид байгаль орчны хариуцлагатай уурхайн үйл ажиллагаа явуулдаг, Иймд:

- Энержи Ресурс ХХК-ийн уурхай, дагалдах инженерийн бүтцийг байгаль орчинд аль болохоор бага нөлөөлөл учруулахаар зохион байгуулна.
- Энержи Ресурс ХХК нь шаардлагатай бүх байгаль орчны стандартуудыг мөрдөж, байгаль орчинд учирч болзошгүй нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийг авна.

Бид нийгмийн хариуцлагатай уурхайн үйл ажиллагаа явуулдаг, Иймд:

- Энержи Ресурс ХХК нь иргэд, засаг захиргааны байгууллага, харилцагч, нийлүүлэгчидтэй "сайн хөрш"-ийн харилцааг хөгжүүлнэ.
- Энержи Ресурс ХХК нь иргэдэд чиглэсэн бодлого хөтөлбөрүүдээр дамжуулан нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулна.

Компанийн сайн засаглал нь Энержи Ресурс ХХК-ийг ажиллуулах, удирдах, хяналтыг хэрэгжүүлэх үзэл баримтлал гэж бид үздэг, Иймд:

- Энержи Ресурс ХХК нь олон улсын шилдэг туршлагыг үйл ажиллагаандаа нэвтрүүлнэ.
- Энержи Ресурс ХХК нь компанийн засаглалын соёлыг байгууллагынхаа хөгжлийн салшгүй хэсэг болгон мөрдөнө.

КОМПАНИЙН ТУХАЙ

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Энержи Ресурс ХХК нь Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дахь Ухаа Худаг коксжих нүүрсний ордод 2009 оноос эхлэн үйл ажиллагаа явуулж байна. Тус компани нь Монгол Улсын хөгжил, дэвшил, үйлдвэржилт, шинэчлэлд өөрсдийн бодитой хувь нэмрийг оруулах, сайн чанарын коксжих нүүрс, нүүрсэн бүтээгдэхүүнээр олон улсын зах зээлд өрсөлдөх эрхэм зорилготойгоор ажиллаж байна. Бид тэргүүлэгч зэргийн коксжих нүүрсний брэндийг бий болгож, бүс нутгийн төдийгүй дэлхийн зах зээлд таниулах зорилтын хүрээнд үйл ажиллагааныхаа бүхий л үе шатанд олон улсын жишиг стандартуудыг мөрдлөг болгодог.

Энержи Ресурс компанийг М-Си-Эс групп, Петровис ХХК, Шунхлай групп зэрэг дотоодын зах зээлд танигдсан, үндэсний хэмжээний томоохон компаниудын хамтын хөрөнгө оруулалттайгаар байгуулсан бөгөөд дэлхийн 61 оронд үйл ажиллагаа явуулдаг олон улсын санхүүгийн байгууллага болох Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк 2009 онд тус компанийн хувь нийлүүлэгчдийн нэг болсон.

Ухаа Худаг уурхай нь жилдээ 15 сая тонн нүүрс угаах хүчин чадал бүхий Монголын анхны нүүрс баяжуулах үйлдвэр, 18 мега ваттын цахилгаан станц, ус хангамжийн систем зэрэг дэд бүтцийн бүтээн байгуулалтыг цогцоор нь шийдвэрлэн, орчин үеийн дэвшилтэт технологид суурилан үйл

ажиллагаагаа явуулж байна. Мөн орон нутгийн дэд бүтцийн хөгжилд хувь нэмэр оруулах зорилгоор “Цэций” орон сууцны хороолол, “Мөрөөдөл” сургууль цэцэрлэг, дотуур байрны цогцолбор зэргийг барьж байгуулахын зэрэгцээ, Ухаа Худаг төслийн дэд бүтцийг шийдвэрлэх хүрээнд орон нутгийн иргэдийг найдвартай эрчим хүч болон цэвэршүүлсэн ундны усаар хангаж байна.

Өнгөрч буй хугацаанд Энержи Ресурс ХХК нь нийт нэг их наяд гаруй төгрөгийг уурхайн болон дагалдах дэд бүтцийн төслүүдэд хөрөнгө оруулалт хийхэд зарцуулсан төдийгүй 2009 онд үйл ажиллагаагаа эхэлснээс хойш өнөөг хүртэлх хугацаанд 400 орчим тэрбум төгрөгийг татвар, шимтгэл хэлбэрээр улсын төсөвт төвлөрүүлжээ. Мөн тус компани байгуулагдсан цагаасаа хойш орон нутгийн иргэдтэй сайн хөршийн харилцааг хөгжүүлж, нээлттэй өдөрлөг, хэлэлцүүлэг зохион байгуулах замаар олон нийтийн санал бодлыг төсөл хэрэгжилтийн явцад тусгаж ирсэн бөгөөд үйл ажиллагаагаа эхлүүлснээс хойш жил бүр ойролцоогоор 1 тэрбум гаруй төгрөгийг зөвхөн орон нутгийг хөгжүүлэх, чадавхижуулах төсөл, хөтөлбөрүүдэд зарцуулдаг. Ухаа Худаг төслийн хүрээнд дотоодын нийт 700 орчим байгууллага, аж ахуйн нэгжтэй туслан гүйцэтгэгч, бэлтгэн нийлүүлэгч хэлбэрээр идэвхтэй хамтран ажиллаж ирсэн.



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Компанийн сайн засаглалыг төлөвшүүлэх нь Энержи Ресурс ХХК нь дэлхийн жишигт нийцсэн уул уурхайн үйлдвэрлэлийн цогцолбор байгуулан, улсдаа тэргүүлэгч аж ахуйн нэгж байх гол тулгуур хүчин зүйл гэж бид үздэг.

Компанийн хувь нийлүүлэгчид, Төлөөлөн Удирдах Зөвлөл болон гүйцэтгэх удирдлага нь Компанийн эрхэм зорилго, алсын хараа, эрхэм зүйлс, зорилтуудад компанийн сайн засаглалын олон улсын шилдэг туршлагыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, компанийн засаглалын соёлыг байгууллагынхаа хөгжлийн салшгүй хэсэг болгон мөрдөх талаар тусгаж баталгаажуулсан.

Энержи Ресурс ХХК нь дотоодын болон олон улсын хэмжээнд мөрдөгддөг, сайн засаглалын шаардлагуудыг биелүүлэн ажилладаг төдийгүй нээлттэй, ил тод, хариуцлагатай байдал, шийдвэр гаргалтын энгийн, түргэн шуурхай орчныг бүрдүүлэхүйц байдлаар дотоодын дүрэм, журмуудын хэрэгжилтийг хангадаг.

Монгол Улсын хөдөлмөрийн тухай хууль тогтоомжийн дагуу ажиллагсдыг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад тохирсон, ажлын байрны дарамтнаас ангид нөхцлөөр хангах, хөдөлмөрийн үр дүнд нь тохирсон цалин хөлс олгох, нийгмийн даатгалд даатгуулах зэрэг үндсэн заалтуудыг чандлан мөрдөхийн зэрэгцээ Монгол Улсын нэгдэн орсон Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагын конвенц болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад акт, хамтын гэрээ хэлэлцээрийг дагаж биелүүлдэг.

Компанийн ёсзүйн код нь ажлын байран дээрх ялгаварлан гадуурхалт, ашиг сонирхлын зөрчил, авилгал хээл хахууль зэрэг зүй зохисгүй үйлдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор ажиллагсдад удирдамж, зааварчилгаа болдог. Энэхүү ёсзүйн кодын хүрээнд ажиллагсад болон бусад оролцогч талууд бизнесийн ёс зүйн өндөр стандартыг баримтлан ажиллаж бүхий л төрлийн зохисгүй үйлдлээс урьдчилан сэргийлэх улмаар таслан зогсоохыг эрмэлздэг.

Бид хүний эрхийг дээдэлж, үйл ажиллагааныхаа хүрээнд орон нутгийн иргэдийн болон ажиллагсдынхаа эрхийг зөрчихгүй байх талаар анхаарч ажилладаг төдийгүй хүний эрхийн эрсдлийн үнэлгээг хийж, түүний дагуу хөтөлбөр боловсруулж, сургалт зааварчилгааг холбогдох ажиллагсдад өгдөг. Түүнчлэн оролцогч сонирхогч талуудынхаа итгэлийг хүлээх үүднээс бид нээлттэй, ил тод үйл ажиллагаа явуулахыг

эрхэмлэн ажилладаг. Энэхүү зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа олон нийт, хөрөнгө оруулагчид болон бусад төр засгийн төдийгүй олон улсын банк санхүүгийн байгууллагуудад нээлттэй тайлагнасаар ирсэн. 2009 онд үйл ажиллагаагаа эхлүүлсэн үеэс Олборлох Үйлдвэрийн Ил Тод Байдлын Санаачлагад нэгдэн, төр засгийн байгууллагад төлсөн төлбөр, татвар хураамжаа нээлттэй тайлагнадаг нь Монгол улсад сайн засаглал, ил тод байдал, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэхэд түлхэц болно гэж үздэг.

2013 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ, БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

2013 онд дан ганц нүүрсний салбар гэлтгүй улс орны эдийн засаг, уул уурхайн салбарын хувьд хүндхэн жил байсан ч Энержи Ресурс компанийн зүгээс бүтээмжээ нэмэгдүүлэх, зардлаа бууруулах, үйл ажиллагааны оновчтой зохион байгуулалтад шилжих зэргээр дотоод нөөц бололцоогоо дээд зэргээр дайчлан ажиллалаа. Тайлант онд хийсэн бүтээн байгуулалтуудыг дор жагсаав.

“Мөрөөдөл” боловсролын цогцолбор

Өмнөговь аймгийн Цогтцэций суманд олон улсын жишигт нийцсэн боловсролын орчин үеийн томоохон цогцолбор байгуулж, 2013 оны 1-р сарын 24-ний өдөр нээлтээ хийлээ. Нийт 700 хүүхдийн дунд сургууль, 144 хүүхдийн цэцэрлэг, 100 хүүхдийн дотуур байр бүхий орчин үеийн тохижилт, шийдэлтэй “Мөрөөдөл” цогцолборыг Өмнөговь аймгийн ЗДТГ болон Энержи Ресурс компанийн хамтын хөрөнгө оруулалтаар байгуулсан.



Цогцолборын нээлт

Барилга байгууламжийн хувьд нэн орчин үеийн дэвшилттэй болсноос гадна сургалтын менежментийн хамгийн орчин үеийн аргачлал нэвтэрсэн, англи хэлийг эх хэлний түвшинд

эзэмшүүлэх DynEd хөтөлбөртэйгээс гадна хичээлээс гадуурх хөтөлбөр, дугуйлангийн сургалттай зэргээрээ онцлог давуу талтай.

Боловсролын чанар, хүртээмж харьцангуй сул байдаг хөдөө орон нутагт ийнхүү олон улсын жишигт нийцсэн, өндөр стандарт шаардлагыг хангасан, орчин үеийн шийдэлтэй цогцолбор байгуулагдсанаар чадварлаг боловсон хүчин олноор бэлтгэгдэж, сумдын хөгжлийг түргэтгэх бодитой эх суурь тавигдаж байна. Мөн улсын тэргүүний Орчлон сургуулийн менежментийг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулснаар боловсролын чанарыг урт хугацаанд тогтвортой нэмэгдүүлэх боломж бүрдэж байгаа юм.

Нүүрс баяжуулах үйлдвэрийн 3-р модуль

Ухаа Худаг дахь Монголын анхны Нүүрс баяжуулах үйлдвэрийн 3-р модулийг төлөвлөсөн хугацаандаа буюу 2013 оны 6-р сард ашиглалтад оруулснаар үйлдвэрийн нийт хүчин чадал жилийн 15 сая тоннд хүрсэн. Ингэснээр Монголын нүүрсний үнэ цэнийг нэмэгдүүлж, өрсөлдөх чадварыг сайжруулаад зогсохгүй, боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх ажилд чухал алхам болсон.



Нүүрс баяжуулах үйлдвэрийн 3-р модуль

“Цэций” орон сууцны хороолол

Орон сууцны “Цэций” хорооллын хүрээнд өдгөө 2013 оны байдлаар нийт 600 айлын 9 орон сууц шинээр ашиглалтанд орсон.

Бүрэн тавилгатай, тохилог орон сууцнууд шинээр үүд хаалгаа нээснээр компанийн ажиллагсад болон сумын иргэдийн ая тухтай ажиллаж, амьдрах нөхцөл бүрэн хангагдаад зогсохгүй сумын нийгмийн ачааллыг бууруулж, уурхай дагасан тогтвор суурьшил бий болж, хөдөөгөөс хот руу чиглэсэн урсгалыг сааруулахад бодитой хувь нэмэр оруулж байна.



“Цэций” хороолол

Хаягдлыг усгүйжүүлэх үйлдвэр

Тайлант онд нүүрс баяжуулах үйлдвэрийн дэргэд Хаягдлыг усгүйжүүлэх үйлдвэрийг барьж, ашиглалтанд оруулсан.

Шинэ үйлдвэр нь яг энэ чиглэлдээ Монголын хамгийн анхны бөгөөд энгийнээр тайлбарлахад 10 литр хаягдал үйлдвэрээс гарлаа гэхэд түүнээс 7–8 литр ус шавхаж гаргаад, эргээд үйлдвэртээ ашиглах бололцоог олгож байгаа. Өмнө нь Нүүрс баяжуулах үйлдвэрийн хаягдлыг 5 км орчимд зөөвөрлөөд, хиймэл нууранд оруулж, усыг нь тунгааж авах замаар үйлдвэртээ усыг дахин ашигладаг байсан.

Харин шинэ үйлдвэр ашиглалтад орсноор үйлдвэрийн хаягдлыг маш богино хугацаанд усгүй болгож, буцаагаад Нүүрс баяжуулах үйлдвэрийн хэрэгцээний усыг нөхөж байгаагаараа онцлог юм. Ингэснээр хаягдлаас буцаан гаргаж авч, үйлдвэрлэлд ашиглах усны хэмжээ өмнөхөөс дор хаяж 60%–70% нэмэгдсэн нь байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийг багасгаж буй сайн талтай.



Хаягдлыг усгүйжүүлэх үйлдвэр

КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН УДИРДЛАГА

Энержи Ресурс ХХК нь компанийн үйл ажиллагаатай холбоотой үүсэх байгаль орчин болоод нийгэмд үзүүлэх нөлөөллийг тодорхойлж, улмаар эерэг нөлөөллийг дэмжих, сөрөг нөлөөллийг бууруулах тодорхой шат дараатай арга хэмжээнүүдийг авч компанийн нийгмийн хариуцлагыг (КНХ) эхнээс нь зөв хэрэгжүүлэхэд анхаарч КНХ-ын бодлого чиглэлээ тодорхойлон ажиллаж байна.

Байгаль орчин, орон нутгийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, хүний нөөц, эрсдлийн удирдлага, санхүү, дотоод хяналт гэх мэт компанийн бусад бүх газар нэгжүүд өөрсдийн ажлын чиг хүрээнд компанийн нийгмийн хариуцлагыг бий болгон хэвшүүлэх зорилт тавин ажилладаг.

Тус компани нь орон нутгийн иргэд, оролцогч талуудтай зөвлөлдөх, компанийн үйл ажиллагааны талаар үнэн зөв мэдээллийг түгээх, орон нутгийн иргэд, оролцогч талуудаас ирсэн санал гомдлыг барагдуулах, соёлын биет болон биет бус өвийг хадгалах, хамгаалах, орон нутгийн хөгжил, дэд бүтэц, боловсрол, эрүүл мэндийн чиглэлээр төсөл, хөтөлбөрүүд хэрэгжүүлэн ажиллаж байна.

Иймд, компанийн бүхий л түвшинд нийгмийн хариуцлагыг ухамсарлуулж, салбартаа үлгэр жишээч үндэсний компани болох алсын хараатайгаар, зорилтуудаа тодорхойлж, бодлогын бичиг баримт, менежментийн төлөвлөгөөг суурь судалгаанд үндэслэн боловсруулан үйл ажиллагаагаа явуулж байна.

КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН БОДЛОГО, ЧИГ БАРИМЖАА

Энержи Ресурс компанийн хувьд КНХ гэх ойлголтыг дан ганц хандив, тусламж болон богино хугацааны төсөл, хөтөлбөрүүд хэрэгжүүлэх зэрэг

хязгаарлагдмал хүрээнд авч үздэггүй бөгөөд олон улсын болон Монгол Улсын холбогдох хууль тогтоомжуудын хүрээнд хариуцлагатай уул уурхайн зарчмуудыг хэрэгжүүлж, нийгмийн сайн сайхан, улс орны эдийн засгийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулах замаар тогтвортой хөгжлийн бат бэх суурийг бий болгохыг зорьдог.

Иймд Олон Улсын Стандартын Байгууллагаас 2010 оны 10-р сард гаргасан “ISO26000: Нийгмийн хариуцлагын зөвлөмж” болон Олон Улсын Санхүүгийн Корпораци, Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк зэрэг байгууллагуудаас гаргасан удирдамжуудад үндэслэн КНХ-ын бодлогоо боловсруулсан.

Уг бодлогод “Энержи Ресурс ХХК нь Монгол Улсын хөгжил, эдийн засгийн өсөлтөд хувь нэмрээ оруулахдаа компанийн нийгмийн хариуцлагын тухай олон улсын стандарт, олон улсын санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны шаардлагууд болон Монгол Улсын холбогдох стандарт, зарчмуудыг хүлээн зөвшөөрч, тэдгээрт нийцүүлсэн үйл ажиллагааг нээлттэй, ил тод явуулж, хүний эрх, хөдөлмөрийн шударга харилцаа, бизнесийн ёс зүйг дээдлэн хэрэгжүүлнэ” хэмээн заасан. Гүйцэтгэх захирлын тушаалаар 2011 оны 6-р сард КНХ-ын бодлогыг батлаж, компанийн бүх салбар, охин компаниудад танилцуулан, үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлж байна.

Энержи Ресурс ХХК нь Байгаль Орчин, Хөдөлмөрийн Аюулгүй Байдал Эрүүл Ахуйн Удирдлагын Тогтолцоог Олон улсын стандарт “ISO 14001: 2004 Байгаль Орчны Удирдлагын Тогтолцоо”, “OHSAS 18001: 2007 Хөдөлмөрийн Аюулгүй Байдал, Эрүүл Ахуйн Удирдлагын Тогтолцоо”-ны шаардлагад нийцүүлэн компанийн хэмжээнд нэвтрүүлж, хэрэгжүүлж, хэвшүүлэхээр ажиллаж байна.

ОРОЛЦОГЧ, СОНИРХОГЧ ТАЛУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

Компани нь оролцогч болон сонирхогч талуудтай харилцан ашигтай хамтын ажиллагааг бий болгох, мэдээлэл туршлага солилцох, үйл ажиллагаандаа хөндлөнгийн мониторинг үнэлгээ хийлгэх, үйл ажиллагаагаа тайлагнах зэргээр гадаад дотоодын олон байгууллагатай үр өгөөжтэй хамтран ажиллаж байна.

Энержи Ресурс ХХК нь оролцогч, сонирхогч талуудыг татан оролцуулах төлөвлөгөөг 2009 оноос эхлэн хэрэгжүүлж эхэлсэн. Энэхүү төлөвлөгөөнд дараах үндсэн зарчмуудыг тусгасан байдаг:

- Орон нутгийн иргэд Ухаа Худаг төслийн талаар мэдээлэл хүртэх эрхээ эдлэх эрхтэй;
- Компани нь бодлого, төлөвлөлтөндөө оролцогч сонирхогч талуудын санал хүсэлтийг тусгах зарчмыг баримтлан үр дүнтэй хэлэлцүүлгийг аливаа шахалт дарамтгүйгээр, шударгаар явуулах үүрэгтэй;
- Үйл ажиллагааныхаа нийт хугацааны туршид оролцогч сонирхогч талуудын оролцоог хангах үйл ажиллагааг тогтмол явуулах;
- Иргэдийн санал хүсэлт, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх механизмыг бий болгон хэрэгжүүлэх;

Энэхүү менежментийн төлөвлөгөөний дагуу Компанийн үйл ажиллагааны талаар үнэн зөв мэдээлэл түгээхийн зэрэгцээ иргэдтэй нүүр тулж уулзан тэдний ойлголт, хандлага, орон нутгийн зүгээс үүсэх нөхцөл байдлыг тодорхойлох, санал зөвлөмжийг үйл ажиллагаандаа тусгах зорилго бүхий компанийн нээлттэй өдөрлөг, олон нийтийн хэлэлцүүлгийг жил бүр зохион байгуулдаг.

2013 оны 8-р сарын 9-ний өдөр нээлттэй өдөрлөг, хэлэлцүүлгийг компанийн үйл ажиллагааны нөлөөллийн сум болох Цогтцэций

суманд нийт 600 гаруй орон нутгийн иргэдийг хамруулан зохион байгуулсан. Нээлттэй хэлэлцүүлгийн үеэр компанийн үйл ажиллагаа болон орон нутагт оруулж буй нийгмийн хөрөнгө оруулалт, орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжих төсөл хөтөлбөрүүдийн талаар иргэдэд мэдээлэл өгч тэдний сонирхсон асуултанд хариулж, санал солилцсон.



Орон нутгийн иргэд нээлттэй хэлэлцүүлгийн үеэр

Мөн орон нутгийн иргэдтэй нээлттэй харилцааг хөгжүүлж, шийдвэр гаргах явцад тэдний оролцоог хангах, дуу хоолойг тусгах үүднээс Цогтцэций, Баян-Овоо, Ханбогд сумдад орон нутгийн сайн дурын зөвлөл байгуулан тууштай хамтран ажиллаж байна. Компаниас тус зөвлөлүүдтэй сар бүр уулздаг бөгөөд зөвлөл тус бүр 9-11 хүний бүрэлдэхүүнтэй малчид, өрх толгойлсон эмэгтэйчүүд, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын гишүүд, ТББ-ууд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмадын төлөөлөл зэрэг нийгмийн бүхий л төлөөллийг хамруулсан байдаг. Ингэснээр зөвлөл нь нутгийн иргэдийн дуу хоолой болж, тэдний санал зөвлөмжийг компанид уламжлах замаар компани болон иргэдийн хооронд нээлттэй, эрх тэгш оролцоотой байх, хамтын ажиллагаа хөгжих боломжийг нэмэгдүүлж байна.

Түүнчлэн малчид, иргэдийн зүгээс компанийн бүтээн байгуулалтын ажлууд, байгаль орчны мониторинг, нөхөн сэргээлтийн ажилд хяналт тавих байдлаар оролцдог нь компани болон иргэдийн хооронд нээлттэй хамтын ажиллагаа хөгжих боломжийг нэмэгдүүлж байна.

Оролцогч, сонирхогч талуудын оролцоог хангах, үйл ажиллагаагаа ил тод байлгах үүднээс мэдээллийн төв ажиллуулж, сар бүр байгаль орчны мониторингийн дүнг Ухаа Худаг мэдээллийн хуудсаар дамжуулан орон нутгийн иргэдэд мэдээлж, үйл ажиллагааны болон тогтвортой хөгжлийн тайланг хагас жил тутамд олон нийтэд нээлттэй тайлагнаж ирлээ. Түүнчлэн үйл ажиллагаагаа



Нээлттэй өдөрлөг, хэлэлцүүлгийн үеэр

эхлүүлснээс хойш бид Ухаа Худаг уурхайтай танилцах аяллыг төр засгийн болон төрийн бүс байгууллагууд, сэтгүүлчид, орон нутгийн иргэд болон уурхайтай танилцах хүсэлтэй хэн бүхэнд нээлттэй зохион байгуулж, уурхайн үйл ажиллагаатай танилцуулсаар ирсэн нь олон нийтийн итгэлийг хүлээх, тэдний санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусган эргэх холбоотой ажиллахад ихээхэн түлхэц болж байна. Тус компани нь нийгмийн хариуцлагын хүрээнд орон нутгийн удирдлага болон иргэдтэй сайн хөршийн харилцааг хөгжүүлэхэд анхаарч, бүс нутгийн уулзалт, зөвлөгөөнд идэвхи санаачлагатай оролцож, компанийн хэрэгжүүлж буй орон нутгийн хөгжлийн хөтөлбөрүүдээр дамжуулан олон нийттэй, ард иргэдтэй ойр дотно ярилцаж, зөвлөлдөхийг эрхэмлэн ажилладаг.

ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ БАРАГДУУЛАХ МЕХАНИЗМ

Компанийн үйл ажиллагааны улмаас хүний эрх, эрүүл мэнд, аюулгүй байдал мөн байгаль орчинд үүсч болзошгүй аливаа сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлж цаг тухайд нь арга хэмжээ авч байх зорилгоор орон нутгийн иргэд болон ажиллагсдаас ирсэн гомдлыг хүлээн авч шуурхай шийдвэрлэж эргэн мэдээлэх журмыг хэрэгжүүлэн ажилладаг.

Тухайлбал, аливаа өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор хариу өгөхийг зорин, шаардлагатай болон хүсэлт гаргасан тохиолдолд гомдлын нууцлалыг хадгалах ба бүх гомдолд ижил тэгш зарчмаар хандан ажилладаг. Компанийн хэмжээнд 2013 онд нийт 16 гомдол, 23 хүсэлт хүлээн авсан байна. Хүлээн авсан нийт 16 гомдлоос 14 гомдол нь нүүрс тээврийн зам дээр мал дайруулсантай холбоотой, үлдсэн 2 гомдол нь “Цэций” хороолол дээр ажиллаж буй барилгын

гэрээт компани түр ажиллагсдын цалинг хугацаанд нь төлөөгүтэй холбогдолтой байсан. Өнгөрөгч онд Энержи Ресурс компанийн барьж байгуулж, ашиглалтанд оруулсан Ухаа Худаг–Гашуун Сухайт чиглэлийн авто замыг төрийн өмчит компанид шилжүүлэх шийдвэр гарсантай холбоотойгоор 2013 оны 8 сараас эхлэн “Энержи Ресурс” ХХК-ийн нүүрсний тээвэрлэлт гүйцэтгэдэг “Трансговь” ХХК-с гадна төрийн өмчит болон хувийн хэвшлийн 10 гаруй компанийн хүнд даацын машинууд тээвэр хийж эхэлснээр замын хөдөлгөөний эрчим эрс нэмэгдэж мал дайрагдах, бэртээх зэрэг осол аваарын тоо өсч замын хөдөлгөөний аюулгүй байдалд анхаарах шаардлага үүссэн.

Хохирогсдын гомдлыг барагдуулах үүднээс манай компани холбогдох хууль сахиулах байгууллагуудтай хамтран ажиллаж, эзэн холбогдогчдыг илрүүлэн тогтоох, шаардлагатай тохиолдолд хохирогчдын гомдлыг барагдуулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлж, замын аюулгүй байдлын талаар тээврийн жолооч нарт давтан зааварчилгаа өгч, замд ойр нутагладаг малчин айлуудийн гэрээр уулзалт хийн анхааруулга, сэрэмжлүүлэг өгөх ажлыг зохион байгуулсан.

Тайлант хугацаанд хүлээн авсан нийт 23 хүсэлтийн 47% нь мөнгөн тусламж хүссэн хүсэлт, 13% нь худаг ус гаргуулах хүсэлт, үлдсэн нь компанийн худалдан авалт, сургалтын тэтгэлэг үзүүлэх, дадлага хийх зэрэг хүсэлтүүд байсан. Компанийн үйл ажиллагаа явуулж буй сумдад байгуулагдсан Орон нутгийн зөвлөлийн гишүүд иргэдийн өргөдөл, гомдол барагдуулах ажилд оролцож, иргэдэд уг журмыг таниулан мэдээлэхэд хамтран ажиллаж байна.



АЖЛЫН БАЙР, ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦАА

ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГА

Ажиллагсад нь компанийн амжилтын гол хүчин зүйл учраас чадварлаг боловсон хүчин бий болгох, тогтоон барих, сургаж хөгжүүлэх нь манай компанийн хувьд чухал ач холбогдолтой байдаг. Энэ утгаараа компанийн зүгээс ажлын байрны эрүүл, аюулгүй орчинг бүрдүүлж, ажиллагсдынхаа нийгмийн асуудлыг шийдвэрлэх, шилжин суурьших нөхцлийг бүрдүүлэх, хувь хүний болон мэргэжлийн хувьд тасралтгүй өсөн дэвжих боломжийг бүрдүүлэхэд онцгой анхаарч, хүний нөөцийн бодлогодоо тусган ажиллаж байна.

Компанийн ёсзүйн хэм хэмжээний хүрээнд ялгаварлан гадуурхалт, ашиг сонирхлын зөрчил, авилгал хээл хахууль зэрэг зүй зохисгүй үйлдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор ажиллагсдад удирдамж, зааварчилгааг тогтмол өгч хэвшсэн. Энэхүү ёсзүйн хэм хэмжээний хүрээнд ажиллагсад болон бусад оролцогч талууд бизнесийн ёс зүйн өндөр стандартыг баримтлан ажиллаж бүхий л төрлийн зохисгүй үйлдлээс урьдчилан сэргийлэх улмаар таслан зогсоохыг эрмэлздэг.

2013 онд бид компанийн бүтэц, орон тоог оновчлох, улмаар хөдөлмөрийн бүтээмжийг

нэмэгдүүлэх чиглэлд тэргүүн зорилт тавин ажилласан. Энрес технологи ХХК, Энержи ресурс майнинг ХХК, Ухаа худаг Ус хангамж ХХК, Хангад Эксплорэйшн ХХК-ийн ажиллагсдыг Ухаа Худаг салбарт нэгтгэж, нэгдсэн удирдлагаар хангаж эхэллээ. Мөн ажиллагсдыг шилжин суурьшуулах бодлогод нэмэлт өөрчлөлт оруулж, бүх ажиллагсад, ажилласан жил, ажлын туршлагаас үл хамааран “Цэций” орон сууцны хорооллоос компаниас санхүүгийн тусламжтайгаар орон сууц худалдан авах боломжийг бүрдүүлсэн. Тус онд компани нь хүний нөөцийн удирдлагадаа Oracle Enterprise Resource Planning программ хангамжийг нэврүүлж илүү үр өгөөжтэй ажиллах боломжийг эрэлхийлж ажиллав.

АЖЛЫН БАЙР, ТЭГШ БОЛОМЖ

Өнгөрөгч 2013 он нүүрсний болон уул уурхайн салбарт бүхэлд нь хүндээр тусч, олон компаниуд үйл ажиллагаагаа түр буюу бүрмөсөн зогсоохоос өөр аргагүй байдалд орсон хэдий ч Энержи Ресурс ХХК нь ажиллагсдынхаа ажлын байрыг хадгалах, тэр дундаа орон нутгийн иргэдийг ажил, орлоготой нь хэвээр байлгах чиглэлд нэн тэргүүний ач холбогдол өгч, бүхий л бололцоогоо дайчилсны хүчинд ажлын байрыг тогтвортой хадгалж ирлээ.

Хүснэгт 1. Компанийн ажиллагсдын мэдээлэл

	2011/12/31	2012/12/31	2013/12/31
1. Нийт ажиллагсдын тоо	2177	2568	2272
2. Нийт эмэгтэй ажиллагсдын тоо	348	449	324
3. Орон нутгийн ажиллагсдын хувь	29.8%	35.6%	43.3%

Ухаа Худаг уурхайн цогцолборын хүрээнд нийт ажиллагсдадын 43.3% нь орон нутгийн иргэд тодруулбал Өмнөговь аймгийн Цогтцэций, Даланзадгад, Манлай, Баян Овоо, Цогт-Овоо сумын иргэд зонхилон бүрдүүлж байна. Уул уурхайн салбарт эмэгтэй ажиллагсдын эзлэх хувь бусад салбарыг бодвол харьцангуй

бага хувьтай байдаг. Манай компани хүний нөөцийн бодлогын хүрээнд шинэ ажилтан сонгон шалгаруулахдаа хүйсийн тэгш байдлыг хангахыг зорьдог бөгөөд тэдний ажлын туршлага, ур чадварыг ижил хэмжээнд авч үзэж, цалин урамшуулал олгох, хөгжиж дэвшихэд ижил тэгш боломж олгодог. Өнөөдрийн байдлаар компанийн


нийт ажиллагсдын 14%-ийг эмэгтэй ажиллагсад эзэлж байгаа боловч удирдах албан тушаалтай эмэгтэй ажиллагсдын эзлэх хувь 30% –тай байгаа нь бага биш үзүүлэлт юм.

Ухаа Худаг уурхайн үйл ажиллагаа эхэлсэн 2009 оноос хойш эрчтэй өрнөсөн бүтээн байгуулалт, ажлын далайцаас шалтгаалан ажиллагсдын тоо


хурдацтай өсч Цогтцэций суманд шилжин суурьших ажиллагсдын тоо ч нэмэгдсээр байна.

Энэ утгаараа компанийн зүгээс тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэх, шилжин суурьших нөхцөлийг бүрдүүлэх, хувь хүний болон мэргэжлийн хувьд тасралтгүй өсөн дэвжих боломжийг бүрдүүлэхэд онцгой анхаарч, хүний нөөцийн бодлогодоо тусган ажиллаж байна.


Эмэгтэй ажиллагсдын эзлэх хувь (2013)




Орон нутгийн ажиллагсдын эзлэх хувь (2013)



Ажиллагсдын насны ангилал (2013)



Эмэгтэй удирдах албан тушаалтны эзлэх хувь (2013)



АЖИЛЛАГСДЫН ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨН

2013 онд ажиллагсдын шилжилт хөдөлгөөн 27.9%-д хүрч өнгөрөгч оныхоос 3.9%-иар өссөн байна.

Тайлант онд тус компанийн хэрэгжүүлэн ажиллаж байсан Ухаа Худаг-Гашуун Сухайт чиглэлд төмөр зам барих төслийг Монгол Улсын Засгийн газраас үргэлжлүүлэн хэрэгжүүлэх болсон, мөн компанийн хэрэгжүүлж байсан нүүрс баяжуулах үйлдвэрийн 3-р модулийн төсөл хэрэгжиж дууссан, Паблик сервис ХХК-ийг худалдсан, СТЛ буюу шингэрүүлсэн түлш гаргаж авах төслийг М-Си-Эс Холдинг компанид шилжүүлсэн зэрэг шалтгаанууд нь ажиллагсдын шилжилт хөдөлгөөн

ийнхүү нэмэгдэхэд нөлөөлсөн байна. Мөн зарим ажиллагсдын хөдөлмөрийн гэрээ цуцлах болсон үндсэн асуудлын нэн тэргүүнд хөдөлмөрийн дотоод журам зөрчсөн болон гэр бүлийн шалтгаан орж байна.

Зах зээлийн нөхцөл байдал, компанийн бүтэц, зохион байгуулалт, орон тоог оновчлох үйл ажиллагааны хүрээнд ажлаас хүсэлтээрээ гарсан ажилтныг нөхөж шинэ ажилтан авахгүйгээр зохион байгуулалт хийсэн нь шилжилт хөдөлгөөний чанарт мөн нөлөөлсөн. Хэдийгээр өнгөрөгч онд ажиллагсдын шилжилт хөдөлгөөн нэмэгдсэн боловч энэ нь хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх компанийн бодлоготой уялдаатай юм.

СУРГАЛТ, ХӨГЖИЛ

Компани байгуулагдсан цагаас эхлэн ажилтнуудынхаа мэргэжлийн ур чадварыг сайжруулах, хувь хүний ерөнхий ур чадварыг нэмэгдүүлэх, байгууллагын соёлыг төлөвшүүлэх сургалтуудыг тогтмол зохион байгуулж байна. Бид ажиллагсдаа сургаж, хөгжүүлэх тусам компанийн амжилт улам бүр бодитоор нэмэгдэнэ гэж үздэг.

2013 онд компанийн дотоод нөөц бололцооны хүрээнд хийгдэх боломжтой ажлын байран дээрх сургалтыг түлхүү зохион байгуулж ажиллалаа. Энэ хугацаанд давхардсан тоогоор нийт 643 ажиллагсдыг 71 төрлийн сургалтанд хамруулсан бөгөөд үүнээс 340 хүнийг ерөнхий ур чадварын 20 төрлийн сургалтанд, 303 хүнийг 51 төрлийн мэргэжлийн сургалтанд тус тус хамруулсан.

АЖИЛЛАГСДЫН НИЙГМИЙН ХАЛАМЖ, ХАМГААЛАЛ

Компанийн зүгээс ажиллагсдын цалин хангамж, урамшуулал болон нийгмийн халамжийн чиглэлээр тодорхой бодлого, журмыг хэрэгжүүлэн ажилласаар ирсэн. Ажиллагсдыг суурьшуулах бодлогын хүрээнд Цогтцэций суманд барьж байгуулж буй “Цэций” орон сууцны хороололд компанид тогтвор суурьшилтай ажилласан жилээс нь хамаарч

хувьд нь өгөх нөхцлийг өөрчиллөө. Салбарын бодит байдал, нүүрсний зах зээлийн хямралаас хамаарсан ажиллагсдын шилжилт хөдөлгөөнтэй холбоотойгоор шинэчилсэн журмаар ажиллагсад компанид ажилласан жилээс үл хамааран урт хугацааны зээлд хамрагдан орон сууцаа өөрийн өмчлөлд шилжүүлэн улмаар ажиллаж буй хугацаандаа зээлийн урьдчилгаа, хүүний төлбөртөө компаниас дэмжлэг авах нөхцлийг бүрдүүллээ.

2013 онд 302 өрхийн орон сууцыг ашиглалтанд оруулж, хүлээж авснаар нийт 400 орон сууцанд компанийн ажиллагсад суурьшин амьдарч байна.

Компанийн санхүүгийн нөхцөл байдал болон хувь хүний ажлын гүйцэтгэл, багийн гүйцэтгэлээс хамааран ажиллагсдад гүйцэтгэлийн урамшууллыг тооцон олгодог бөгөөд нийт ажилтнуудаа орон сууц худалдан авахад нь банкны хөнгөлөлттэй зээл, даатгал, эрүүл мэндийн үзлэгт хамруулах, гэр бүлээрээ нүүн суурьшиж буй ажилтнуудын гэр бүлийг ажилд ороход нь дэмжлэг үзүүлэх, мөн ажиллагсад хүүхдүүдийнхээ сургууль цэцэрлэгийн асуудлыг шийдэхэд нь тусламж, дэмжлэг үзүүлэх зэргээр ажиллагсдын нийгмийн асуудалд анхаарал хандуулсаар ирлээ. Мөн ажилтнуудын зүгээс гаргаж буй урлаг, спортын санал санаачлагыг дэмжиж, баг хамт олны дунд хамтач, зэрэг уур амьсгал бий болгоход анхаарч ажиллалаа.



ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛД ОРУУЛЖ БУЙ ХУВЬ НЭМЭР

ТАТВАР ТӨЛӨЛТ

Энержи Ресурс ХХК нь үйл ажиллагаа эхлүүлсэн жил буюу 2009 онд 13 тэрбум, 2010 онд 54 тэрбум, 2011 онд 116.5 тэрбум, 2012 онд 163.2 тэрбум төгрөгийг улсын төсөвт тус тус төвлөрүүлсэн.

2013 онд дан ганц нүүрсний салбар гэлтгүй уул уурхайн салбарын хувьд амаргүй, хүндхэн жил байсан боловч компанийн зүгээс бүтээмжээ нэмэгдүүлэх, зардлаа бууруулах, үйл ажиллагааны оновчтой зохион байгуулалтад шилжих зэргээр дотоод нөөц бололцоогоо дайчлан ажилласны үр дүнд өмнөө тавьсан зорилго, зорилтуудаа бүрэн гүйцэд биелүүлж, 52 тэрбум төгрөгийн татварыг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Компанийн орон нутагт оруулж буй хөрөнгө оруулалт нь тус бүс нутгийн тогтвортой хөгжлийг дэмжиж, цаашлаад орон нутгийн иргэд төдийгүй компанид ч үр өгөөжөө өгөх зорилгыг агуулдаг. Энержи Ресурс ХХК нь 2013 онд нийт 12.2 тэрбум төгрөгийг орон нутгийн хөгжилд зарцуулсан. Үүнд дэд бүтэц болон орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжихэд чиглэсэн төсөл хөтөлбөрүүд болон томоохон бүтээн байгуулалтууд багтаж байна.

Орон нутаг төдийгүй улс орны хэмжээнд хөгжлийн чухал хөшүүргүүдийн нэг нь дэд бүтцийн асуудал байдаг. Энержи Ресурс ХХК үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойшхи 5 жилийн хугацаанд Ухаа Худагт өргөн цар хүрээтэй бүтээн байгуулалтыг өрнүүлж, уурхай дагасан дэд бүтцийн шийдлийг цогц утгаар бүрдүүлж байна. Тэрчлэн уурхайн дэд бүтцийг орон нутгийн дэд бүтцийн хөгжилтэй уялдуулах бодлогын хүрээнд төвийн эрчим хүчний системээс алслагдсан Цогтцэций сумыг тог, цахилгаанаар найдвартай хангахаас гадна ундны цэвэршүүлсэн усаар хангадаг.

Бид орон нутгийн дэд бүтэц, боловсролын хүртээмж, орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, мэдлэг чадварыг сайжруулахад анхаарал тавин ажиллахаас гадна малчдын жижиг дунд үйлдвэрлэл эрхлэх боломжийг бий болгож, чадавхижуулах чиглэлээр бие даасан төсөл хөтөлбөр хэрэгжүүлэн ажилладаг.

Мөн компанийн худалдан авалтын бодлого, хүний нөөцийн бодлогоо орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжихэд чиглүүлж өнгөрөгч онд дотоодын нийт 523 гаруй аж ахуйн нэгжтэй бэлтгэн нийлүүлэгч, туслан гүйцэтгэгч хэлбэрээр хамтран ажиллаж, зөвхөн Өмнөговь аймгийн хэмжээнд 1.7 тэрбум төгрөгийн худалдан авалтыг хийсэн байна

Хүснэгт 2. Нийгэм орон нутагт оруулсан хөрөнгө оруулалтын нэгтгэл [2013]

Хөрөнгө оруулалтын чиглэл	MNT
1. Орон нутгийн дэд бүтцийн хөгжил	7,850,694,256
2. Төсөл хөтөлбөрүүд	2,601,349,056
3. Хандив, тусламж	2,990,980
4. Орон нутгийн худалдан авалт	1,748,300,000
НИЙТ	12,203,334,292

ОРОН НУТГИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРҮҮД

Компани нь нийгмийн нөлөөллийн үнэлгээ, хүн ам, эрүүл мэнд, хүний эрх, соёлын өв зэрэг нийгмийн олон чиглэлийн суурь судалгаа болон иргэдийн нээлттэй хэлэлцүүлгийн санал санаачлагыг үндэслэн орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжих төсөл, хөтөлбөрүүдийг тууштай хэрэгжүүлж байна.

Өнгөрөгч хугацаанд эдгээр төсөл хөтөлбөрүүдийг орон нутгийн иргэд, олон нийт болон засаг захиргааны байгууллагуудын оролцоотойгоор

хамтран хэрэгжүүлсээр ирлээ. Тайлант хугацаанд компанийн зүгээс доорх төсөл, хөтөлбөр, санаач- лагуудыг хэрэгжүүлсэн.

Оюутны тэтгэлэгт хөтөлбөр

Улсын хэмжээнд шилдэг оюутан залуусыг дэмжиж урамшуулах, инженер техникийн ирээдүйн чадварлаг боловсон хүчнийг бэлтгэх зорилготойгоор Энержи Ресурс ХХК-иас зохион байгуулдаг “Ирээдүйн сайн сайхны төлөө” оюутны тэтгэлэгт хөтөлбөрийн 2013–2014 оны хичээлийн жилийн тэтгэлэгт оюутнууд тодорч нийт 17 оюутан батламжаа гардан авсан.

2009 оноос эдүгээ тавдахь жилдээ амжилттай зохион байгуулагдаж буй энэхүү хөтөлбөрийн хүрээнд өнөөдрийг хүртэл 178 оюутан тэтгэлэг хүртээд байгаа юм.

Шалгарсан оюутнууд суралцах хугацааныхаа турш сар бүр мөнгөн тэтгэлэг хүртэхээс гадна Ухаа Худаг аж үйлдвэрийн цогцолборын үйл ажиллагаатай биечлэн танилцаж, улмаар уурхайд үйлдвэрлэлийн дадлага хийх боломжоор хангагддаг давуу талтай.



2013 оны тэтгэлэгт оюутнууд

Цогтцэций сумын Ерөнхий боловсролын дунд сургуулийг чадавхижуулах төсөл

Энержи Ресурс ХХК нь Цогтцэций сумын Ерөнхий боловсролын дунд сургуулийг англи хэл, математикийн гүнзгийрүүлсэн сургалттай болгох тусгайлсан хөтөлбөрийг улсын тэргүүний Орчлон сургуулийн төслийн менежментийн багтай хамтран хэрэгжүүлж, 2013 онд төслөө дүгнэсэн. Уг хөтөлбөр хэрэгжиж эхэлснээр 9 жилийн сургалтын хөтөлбөртэй дунд сургууль стандарт буюу 12 жилийн сургалтын хөтөлбөртэй болсноос гадна гадаад хэлний гүнзгийрүүлсэн сургалтын эрхийг албан ёсоор авсан нь хөдөө орон нутгийн

сургуулийн сургалтын чанарт ахиц гарах чухал алхам болсон.



Олимпиадад амжилттай оролцсон сурагчид

Өнгөрсөн хугацаанд хөтөлбөрийн хүрээнд тус сургууль англи хэлний DynEd олон улсын сургалтын хөтөлбөрийг нэвтрүүлж, сургалтын орчныг шинэчилсэн төдийгүй математик ба англи хэлний өндөр ур чадвартай багш нарыг урилгаар авч ажиллуулж хот хөдөөгийн сургуулийн сургалтын чанарын зөрүүг багасгах мөн түүнчлэн багшлах боловсон хүчинг сайжруулахад хувь нэмэр оруулж байна.

Сүүлийн жилүүдэд улс аймгийн чанартай олимпиадуудад Цогтцэций сумын сургуулийн багш, сурагчид тасралтгүй оролцож, тухай бүр өндөр амжилт үзүүлэх болсон төдийгүй өнгөрсөн хаврын элсэлтийн ерөнхий шалгалтын дүнгээр аймгийн нийт 11 сургуулийн дундаас англи хэлний хичээлээр 1-р байр, математикийн хичээлээр 2-р байр тус тус эзэлсэн үзүүлэлтэйгээр уг хөтөлбөрийн үр дүнг тодорхойлж болох юм.

Ухаа Худаг наадам

Үндэсний их баяр наадам нь Монголчуудын түүх, соёлыг харуулсан чухал баярын нэг төдийгүй соёлын биет бус өв уламжлалын эх сурвалж байдаг билээ. Энержи Ресурс компаниас орон нутгийн иргэдэд хүндэтгэл үзүүлэх, компанийн үйл ажиллагаагаа сурталчлан таниулах, соёлын өв, уламжлалт ёс заншлаа түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Ухаа Худаг” наадмыг жил бүр зохион байгуулдаг ба наадмын цар хүрээ жилээс жилд өргөжиж, тус наадамд нутаг нутгийн хүчит бөхчүүд, алдарт уяачид, эрхийн мэргэн харваачид ирж өрсөлддөг нутгийнхны хүсэн хүлээдэг арга хэмжээ болжээ.

2013 оны хувьд компанийн их бүтээн байгуулалтын таван жилийн ой тохиож байгаа онцлогтой байсан төдийгүй Өмнөговь аймгийн зүүн бүсийн сумдыг

хамруулан “Ухаа Худаг” наадмыг Цогтцэций суманд 8-р сарын 09-ний өдөр өргөн дэлгэр зохион байгууллаа. Тус наадамд хүчит 64 бөх, өсвөрийн 32 бөх барилдаж, дөрвөн насны хурдан морины уралдаан болж, халх сурын харваанд эрхий мэргэн харваачид цэц мэргэнээ сорин наадлаа. Мөн наадамчин олны дунд сайхан морьтой, сайхан хос шалгаруулж, наадмын нээлт, хаалт, үдшийн цэнгүүнд Монгол улсын урлагийн алдартнуудын төлөөлөл оролцож, баяр наадмыг чимж, наадамчин олноо баясган цэнгүүлээ.



Ухаа Худаг наадмын үеэр

Өмнийн говийн уран бүтээлчийг дэмжиж хамтран ажиллаж байна

Өмнийн говиос төрж гарсан авъяаслаг залуу уран бүтээлчдийн нэг, тус аймгийн Хөгжимт Жүжгийн Театрын гоцлол дуучин, МУСТА Б.Цэрэн-Очир “Дүүрэн заяатай Монгол минь” хэмээх цомгоо гаргаж, анхны уран бүтээлийн тайлан тоглолтоо Улаанбаатар хотноо 2013 оны 4-р сарын 12-ны өдөр зохион байгуулсан билээ.

Нутгийнхаа нэрийг өргөж яваа залуу дуучны уран бүтээлийг компанийн зүгээс дэмжиж, цомог болон анхны тоглолтыг ивээн тэтгэж хамтран ажиллалаа.

Малчдын тогтвортой амьжиргааг дэмжих хөтөлбөр

Компаниас уул уурхай эрчимтэй хөгжиж буй нөлөөллийн бүс дэх малчин айл өрхүүдийн амьжиргааг дэмжих, байгалийн гамшиг, нийгэм, эдийн засгийн хүчин зүйлст өртөмхий байдлыг бууруулах, өрхийн бизнесийн менежментийг сайжруулах замаар бизнесийн үйл ажиллагааг хөгжүүлэх зорилгоор “Малчдын тогтвортой амьжиргааг дэмжих хөтөлбөр”-ийг санаачлан хэрэгжүүлж байна.

Хөтөлбөрийн зорилго нь компанийн үйл ажиллагааны нөлөөллийн бүсэд нутагладаг болон нүүлгэн шилжүүлэлтэнд хамрагдсан малчдын эрхийг хүндэтгэн, уурхай, зам тээврийн хөгжилтэй зэрэгцэн хөгжих мал аж ахуй, фермер, газар тариалан, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэлт зэрэг тэдгээр өрхүүдийн өөрсдийн сонгосон аж ахуйн хэлбэрийг дэмжих, улмаар малчдын тогтвортой амьжиргааг хангахад оршино.

Нэн тэргүүнд хөтөлбөрт хамрагдах Цогтцэций, Баян-Овоо, Ханбогд сумдын 63 малчин өрхийн дунд нийгэм, эдийн засгийн байдлын мониторинг судалгаа мөн тэдний амьжиргааны өнөөгийн нөхцөл байдал, аж ахуй эрхлэх сонирхол, чадавхи, эрэлт хэрэгцээг тодорхойлсон.

Судалгааны үр дүнд малчин өрхүүд мал аж ахуй, газар тариалан, жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаагаа өргөжүүлэх, шинээр эрхлэн өрхийн орлого, амьжиргаагаа дээшлүүлж, орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулах боломжтойг тодорхойлсон.

Бизнесийн менежмент, маркетингийн суурь ойлголт, хамтын оролцоог хөгжүүлэх, байгалийн нөөцийн хамтын менежментийг хөгжүүлэх, мал аж ахуйг эрчимжүүлэх, мал аж ахуйн бүтээгдэхүүний үнэлэмжийг нэмэгдүүлэх зэрэг үндсэн сэдвүүдээр сургалт явуулсан.

Сургалтын үр дүнд малчдын өнөөгийн эрхэлж байгаа бизнесийн төрөл, нөхцөл байдлыг тодорхойлж цаашид хэрэгжүүлэх боломжтой бизнес, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйлчилгээний жагсаалт гарсан байна. Мөн малчин өрх бүрийн бизнесийн зорилго, зорилтыг тодорхойлж одоогоор 49 өрх цаашид эрхлэх бизнесийн чиглэлээ мал аж ахуй газар тариалангийн хүрээнд сонгож, бизнесийн төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхэд бэлэн болоод байна. 2014 оноос уг төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх юм.



Малчид бизнесийн сургалтанд хамрагдав

Ургацын баяр

Цогтцэций сумын Наймантын хөндийд байгуулсан салхины хамгаалалт бүхий ойн 3 га зурваст усалгааны систем бүхий талбай тусгайлан бэлтгэж, орон нутгийн иргэдэд төмс, хүнсний ногоо тариалах, малын тэжээлийн эрдэнэшишийн талбай байгуулах боломжийг бүрдүүлсэн нь үр дүнгээ өгч уг тариалангийн талбайгаас орон нутгийн иргэд хоёрдахь жилдээ ургац хурааж авсан байна. Мөн эдгээр тариаланчдад зориулан компанийн зүгээс хүнсний ногоо тариалалт, арчлалт, хураалт, даршлалт зэрэг хэрэгцээтэй сургалтуудыг үе шаттай зохион байгуулсан.

Энэхүү талбайд 2013 онд орон нутгийн 50 гаруй өрх 10 орчим төрлийн хүнсний ногоо тариалсан нь хангалттай сайн ургац өгч, компанийн хамт олон, нутгийн иргэдтэй хамтран говь нутагт ургацын баяраа тэмдэглэсэн.

Уг арга хэмжээний үеэр сумын иргэдэд зориулсан шинэ ногооны үзэсгэлэн худалдаа зохион байгуулж, хамгийн олон төрлийн ногоо тарьсан болон хамгийн том ногоо хурааж авсан шилдэг ногоочдыг шалгаруулж урамшуулсан юм.



Ургац хураалт

Боловсролын “Мөрөөдөл” цогцолбор үйл ажиллагаагаа эхлүүлээ

Өмнөговь аймгийн Цогтцэций суманд олон улсын жишигт нийцсэн боловсролын орчин үеийн томоохон цогцолбор байгуулагдаж, 2013 оны 1–р сарын 24–ний өдөр нээлтээ хийсэн.

700 хүүхдийн дунд сургууль, 144 хүүхдийн цэцэрлэг, 100 хүүхдийн дотуур байр бүхий өндөр түвшний тохижилт, шийдэлтэй “Мөрөөдөл” цогцолборыг Өмнөговь аймгийн Засаг Даргын Тамгын Газар (ЗДТГ) болон Энержи Ресурс компанийн хамтын хөрөнгө оруулалтаар байгуулсан.



Мөрөөдөл цогцолбор

Нийт хөрөнгө оруулалт болох 8.2 тэрбум төгрөгийн 35% буюу 3.1 тэрбумыг аймгийн ЗДТГ, 65% буюу 5.1 тэрбумыг Энержи Ресурс компаниас тус тус санхүүжүүлсэн байна. Энэ хүрээнд сургуулийн дотоод тохижилт, тоног хэрэгслийн хөрөнгө оруулалтыг компани бие даан санхүүжүүлсэн. Барилга байгууламжийн хувьд нэн орчин үеийн, дэвшилттэй болсноос гадна сургалтын менежментийн хамгийн орчин үеийн аргачлал нэвтэрсэн, англи хэлийг эх хэлний түвшинд эзэмшүүлэх хөтөлбөртэй, хичээлээс гадуурх хөтөлбөр, дугуйлангийн сургалттай зэрэг онцлог, давуу талуудтай юм. Боловсролын чанар, хүртээмж харьцангуй сул байдаг хөдөө орон нутагт ийнхүү олон улсын жишигт стандартын шаардлагыг хангасан, орчин үеийн цогцолбор байгуулагдсанаар чадварлаг боловсон хүчин олноор бэлтгэгдэж, сумдын хөгжлийг түргэтгэх бодитой суурь тавигдаж байна.

Монгол Ганжуур, Данжуурыг хөрвүүлэх үйлс

Энержи Ресурс ХХК нь Компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд биет болон биет бус өвийг хамгаалах, хадгалах хөтөлбөр, төслүүд хэрэгжүүлэн ажилладаг. Энэ ажлын хүрээнд Цогт Цагийн Хүрдэн соёлын төвийн хүсэлтийг хүлээн авч, 2013 оноос эхлэн Монгол Ганжуур, Данжуур их хөлгөн судрыг кирилл бичигт хөрвүүлэн бүтээж, олон нийтийн хүртээл болгох, өв соёлыг түгээн дэлгэрүүлэхэд хувь нэмрээ оруулан, ном судар бүтээх ариун үйлсэд хамтран ажиллаж байна. Одоогийн байдлаар Цогт цагийн хүрдэн соёлын төвийнхөн их хөлгөн судрын хөрвүүлгийн эхний 86 ботийг орчуулан хэвлүүлсэн бөгөөд уг ботийг Улаанбаатар хотноо болон Өмнөговь аймгийн Ухаа Худаг салбар, сумын соёлын төвийн номын санд хүндэтгэн залах ёслолыг амжилттай зохион байгууллаа. Уламжлалт өв соёлыг сэргээх, түгээн дэлгэрүүлэх, орчин цагийн монгол хэлний үгийн санг баяжуулах үндэсний бахархлыг бий болгох гээд өндөр ач холбогдолтой энэхүү буянт үйлсийг компанийн зүгээс талархан дэмжиж, цаашид хамтран ажиллах зорилготой байна.

БАЙГАЛЬ ОРЧИН, ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА ЭРҮҮЛ АХУЙ

Энержи Ресурс ХХК нь үйл ажиллагааныхаа бүхий л үе шатанд ажиллагсдынхаа аюулгүй байдал, эрүүл мэндэд учирч болох сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, байгалийн баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх ажилд нэн тэргүүний ач холбогдол өгч, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжууд болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал (ХАБ), эрүүл ахуйн стандартуудыг мөрдлөг болгон ажиллаж байна.

БОХАБЭА –ЫН УДИРДЛАГА

Энержи Ресурс ХХК нь БОХАБЭА удирдлагын тогтолцоогоо сайжруулах үүднээс олон улсын ISO 14001:2004 (Байгаль орчны удирдлагын тогтолцоо), OHSAS 18001:2007 (Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоо) стандартын шаардлагатай нийцүүлсэн, нэгдсэн удирдлагын тогтолцоог нэвтрүүлэн ажиллаж байна. Энэхүү нэгдсэн удирдлагын тогтолцоо нь Энержи Ресурс ХХК-ийн бүх үйл ажиллагаанд нэвтэрч, компанийн БОХАБЭА бодлого, зорилго, зорилт, шаардлага болон тэдгээрт хүрэх арга замыг тодорхойлсон цогц систем юм. Нэгдсэн удирдлагын тогтолцоог бүрдүүлж хэрэгжүүлэх нь дараах ач холбогдолтой. Үүнд:

- Бодлого, зорилго, зорилтоо үр дүнтэй хэрэгжүүлдэг болно
- Компанийн тогтвортой хөгжлийн тулгуур баталгаа болно
- Компанийн нэр хүнд нэмэгдэнэ, бизнесийн саад тотгор багасна
- Эрсдлийг цогцоор илрүүлж, үнэлж, хянах боломж бүрдэнэ
- Нөөцийг үр дүнтэй ашиглаж, зардал буурна
- Баримт бичгийн болон үйл ажиллагааны тогтмол хяналт улам сайжирна
- Гэрээт болон нийлүүлэгч компаниудын үйл ажиллагаа сайжирна

- БОХАБЭА-н хариуцлагын талаарх мэдлэг мэдээлэл нэмэгдэнэ
- Дотоод аудитын тогтолцоотой болно
- Удирдлагын тогтолцооны байнгын сайжруулалттай болно

Удирдлагын тогтолцоо нь Энержи Ресурс ХХК-ийн хэрэгжүүлж буй бүх төсөл, үйл ажиллагаанд хүчин төгөлдөр мөрдөгдөх бөгөөд үйл ажиллагааны БОХАБЭА гүйцэтгэлийн стандартыг тогтоох зорилготой.

БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГО, ЧИГ БАРИМЖАА

Монгол Улсын хууль тогтоомж, болон олон улсын банк санхүүгийн байгууллагуудын шаардлагад нийцүүлэн Байгаль орчны нарийвчилсан үнэлгээг Ухаа Худаг төсөл эхлэхээс өмнө хийж гүйцэтгэн, төслөөс үүдэлтэй байгаль орчинд учирч болохуйц сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, нөхөн сэргээх зорилготой менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилладаг. Ухаа Худаг уурхайн хүрээнд хог хаягдал, ус, тоосжилт, хөрсний элэгдэл эвдрэл, нөхөн сэргээлт зэрэг чиглэлүүдээр төрөлжсөн бие даасан менежмент төлөвлөгөөнүүдийг хэрэгжүүлж байна. Мөн үйл ажиллагааны явцад байгаль орчинд үзүүлж буй нөлөөллийг хянах зорилгоор орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг боловсруулж, гадаад дотоодын мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлдэг.

Оролцогч талуудын чухал төлөвлөл болох орон нутгийн иргэдийн байгаль орчны мэдлэг боловсролыг дээшлүүлэх зорилгоор сургуулийн сурагчид болон нутгийн малчид, иргэдэд ойжуулалт, зүлэгжүүлэлт, хог хаягдлын менежмент, байгалийн нөөцийн зохистой ашиглалтын талаар сургалт явуулдаг. Түүнчлэн орчны хяналт шинжилгээнд нутгийн иргэдийг оролцуулж, хөндлөнгийн хяналт хийлгэдэг.

БАЙГАЛЬ ОРЧНЫ СУУРЬ СУДАЛГАА

Энержи Ресурс ХХК нь байгаль орчны нарийвчилсан үнэлгээнээс гадна жил бүр төслийн үйл ажиллагаа явагдаж буй Өмнөговь аймгийн Цогтцэций, Ханхонгор, Ханбогд, Баян-Овоо сумдын нутгуудад хөрс, ургамал ба амьтны аймгийн судалгааг байгаль орчны мэргэжлийн байгууллага болон эрдэмтэн судлаачидтай хамтран хийж гүйцэтгэдэг. Өнгөрөгч онд доорх судалгаануудыг хийж гүйцэтгэсэн.

Хөрсөн бүрхэвчийн судалгаа.

2013 онд хийсэн хөрсний хээрийн судалгаагаар Ухаа Худаг уурхайн орчимд тархсан хөрсний судалгааг MNS 3298:1991, MNS 5916:2008 стандартуудын дагуу хийж, 31 цэгт хөрсний бүтэн болон хагас зүсэлт хийж, хөрсний бичиглэл үйлдэн, үе давхаргуудаас дээж авч, итгэмжлэгдсэн лабораторид хөрсний хими, физикийн шинж чанарыг тодорхойлон дүгнэлт гаргасан.

Ухаа Худаг уурхайн орчимд ноёлох хөрсний хэв шинж бол заримдаг цөлийн бор хөрс юм. Хөрсний урвалын орчин 8.2–9.0 шүлтлэг, ялзмагийн дундаж агууламж ядуу 0.5–0.95%, шим тэжээлийн бодисын хангамжийн хувьд 100 грамм хөрсөнд нитрат азот 0.5–15.3мг, нитрат үүсгэх чадвар бага, фосфор 1.8–2.7 мг– ихэвтэр, кали 40–70мг дунд зэргийн хангамжтай, карбонаттай, давстай, 4.3гр/см3 нягттай, элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй физик шаврын $<0.01\text{мм}$ /агууламж 9.2–22.5% байна.

Судалгаа хийгдсэн газар нутгуудад цөлөрхөг хээрийн мараалаг, цөлөрхөг хээрийн хужирлаг бор, цөлөрхөг хээрийн нугархаг бор, цайвар бор зэрэг хэв шинжийн хөрс тэмдэглэгдсэн бөгөөд судалгааны үр дүнд үндэслэн хөрсний хэв шинжийн болон элэгдэл эвдрэлийг тодорхойлсон.

Ургамлын аймгийн судалгаа

Ухаа Худаг уурхай орчим, Наймантын хөндий, Нисэх буудал, Цагаан хад, Ухаа Худгаас Гашуун сухайт хүртэл зам дагуу, Баруун наран уурхай, Баруун наран уурхайгаас Ухаа Худаг уурхай хүртэл зам дагуу байрлах мониторингийн цэгүүд дээр ургамлын бичиглэл үйлдэн ашиглалтын талбай, ойжуулах, нөхөн сэргээх газрын ургамал, төрх байдлыг судалсан. Нийтдээ 13 овгийн 51 төрлийн 75 зүйлийн бүрдэлтэй байна. Үүнээс уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй нэрвэгдэж устах аюулд хүрсэн ургамал байхгүй байна.

Амьтны аймгийн судалгаа

2013 оны зэрлэг амьтдын хээрийн судалгааг “Монголын амьтан судлалын нийгэмлэг” ТББ-ын

судлаачидтай хамтран хийсэн. Ажлын хүрээнд Ухаа Худаг уурхай орчим, Цагаан хад, цагаан хад чиглэлийн зам дагуух газруудад хийсэн. Амьтны аймгийн мониторинг судалгааг хийх нь хулан, хар сүүлт зээр, цагаан зээр, аргаль зэрэг нүүдлийн амьтдын шилжилт хөдөлгөөний гол замналуудыг тодруулах, тэдгээрийг хамгаалах, төслийн янз бүрийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлж байгаа болон учруулж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх менежментийг төлөвлөгөөг боловсруулах үндэс болох зэрэг олон талын ач холбогдолтой.

ГАЗАР АШИГЛАЛТ БА НӨХӨН СЭРГЭЭЛТ

Газрыг зөв зохистой ашиглаж, нөхөн сэргээж улмаар ирээдүйд бэлчээр болон бусад байдлаар ашиглах боломжтой болгож үлдээх нь хариуцлагатай уул уурхайн нэн чухал хэсэг юм. Ухаа Худаг төслийн хүрээнд бид нийт 22,710 га газрыг ашиглах эрхтэй бөгөөд үүнээс 49.9% нь уул уурхайн зориулалтаар, 41.4% уул уурхайн дэд бүтцийн зориулалтаар, 3% нь үйлдвэрийн барилга байгууламж, 6.5% ажиллагсдын орон сууц зориулалтаар ашиглаж байна.

Энержи Ресурс ХХК нь уурхайн олборлолт эхэлснээс хаалт хүртэлх бүхий л хугацаанд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлыг үе шаттайгаар төлөвлөн ажиллаж байна.

Байгаль орчны баг нь 2013 онд байгаль орчны нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд дараах ажлуудыг зохион байгуулан ажилласан.

- Байгаль орчны нөхөн сэргээлтийн туршилтын талбай;
- Хамгаалалтын ойн зурвас;
- Хаягдлын чулуулгын овоолгын нөхөн сэргээлт;
- Үржил шимт хөрсний хуулалт, хадгалалт;



Нөхөн сэргээлтийн туршилтын талбай

- Ус дамжуулах шугам хоолойн нөхөн сэргээлтийн ажил;
- Орчны тохижилт.
- Байгаль орчны нөхөн сэргээлтийн туршилтын талбай

Компанийн байгуулсан байгаль орчны нөхөн сэргээлтийн туршилтын талбай нь биологийн нөхөн сэргээлтэнд зориулан тухайн мод, бут сөөг, нутгийн ургамал болон олон наст ургамлыг туршилтын журмаар ургуулан тухайн бүс нутагт зохицсон ургамлыг сонгон шалгаруулж улмаар үржүүлэн нөхөн сэргээлт болон орчны тохижилт, ойн зурвас байгуулахад ашиглах зорилготой.

Туршилтын талбай нь 2009 онд байгуулагдсан 2.5 га талбайтай бөгөөд дотроо үржүүлгийн хэсэг, эх ургамлын хэсэг, хүлэмж, бойжуулах талбай, хамгаалалтын зурвас, модлог ургамлын туршилтын талбай болон олон наст ургамлын туршилтын талбай гэсэн хэсгүүдтэй.

Одоогийн байдлаар хайлаас, жигд, сухай, улиас, нарс, гацуур, монос, чацаргана, бургас, заг, агч, далан хальс, голт бор, хармаг, хотир, шар хуайс, харгана, гүйлс, буйлс, үхрийн нүд, нохойн хошуу зэрэг 22 төрлийн 26000 орчим мод сөөг, бутлаг ургамлууд болон хялгана, өлөнгө, хиаг, ерхөг зэрэг олон наст ургамлуудыг ургуулж байна.



Туршилтын талбай

Хаягдал чулуулгын овоолгын нөхөн сэргээлт

2013 онд хаягдал чулуулгын овоолго дээр 3 га талбайд биологийн нөхөн сэргээлт хийгдсэн бөгөөд ургамлан бүрхэвч 60–70 хувьтай амжилттай сайн ургаж байна. Тарилтанд ашигласан ургамлын зүйлийн бүрдлийг сонгохдоо улаан, бор бударгана, хотир, хармаг, баглуур зэрэг нутгийн унаган ургамлыг голчлон ашигласан. Мөн ХААИС-тай хамтран говийн нөхцөлд биологийн нөхөн сэргээлтэнд

хэрэглэхэд тохиромжтой олон наст ургамлын сонгох төсөл хэрэгжүүлэн манай нөхцөлд ургах боломжтой нь тогтоогдсон саман ерхөг, дагуур өлөнгө зэрэг үетэн ургамлуудыг хольж тариалсан.



Ус дамжуулах шугам хоолойд техникийн нөхөн сэргээлт хийсэн байдал

БИОЛОГИЙН ТӨРӨЛ ЗҮЙЛИЙГ ДЭМЖИХ

Ойн зурвас төсөл

Байгалийн тэнцвэрт байдлыг хадгалж биологийн төрөл зүйлийг дэмжиж ажиллах нь төслөөс үүдэлтэй байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулахад чухал ач холбогдолтой.

Цогтцэций сумын нутаг нь эх газрын хуурай эрс тэс уур амьсгалтай, агаарын температурын зөрүү өндөртэй, 120мм-с бага хур тунадас жилдээ унадаг, салхины дундаж хурд 5м/с байдаг ч зарим үед хүчтэй салхилж 34 м/с хүртэлх хурдтай шороон шуурга болдог тул энэхүү бүс нутагт салхины хамгаалалтын ойн зурвас байгуулах нь олон талын ач холбогдолтой. Иймээс Энержи Ресурс ХХК-аас салхины хамгаалалтын ойн зурвас байгуулах ажлыг 2011 онд эхэлсэн бөгөөд энэ ажил нь дан ганц салхи шуурга элсний нүүдлээс хамгаалаад зогсохгүй нутгийн иргэдэд ногоо тарих боломжийг олгосноороо иргэдийн амьжиргааг дэмжих томоохон алхам болсон юм.

Салхины хамгаалалтын зурвас нь одоогийн байдлаар 10 га талбайг эзлэх бөгөөд цаашид 50 га хүртэл өргөжүүлэх төлөвлөгөөтэй байгаа нь говийн бүс нутагт байрлах уул уурхайн нөхөн сэргээлтийн ажлын нэгэн жишээ болж байна. Энэхүү салхины хамгаалалтын зурваст гурван жилийн хугацаанд тарьсан хайлаас, улиас, жигд, сухай, чацаргана зэрэг 5 төрлийн 12 мянган мод сөөгийн амьдралтын хувь 90%-ээс дээш хувьтай байна. Мод сөөгний усалгаанд сүүлийн үеийн

дэвшилтэт технологи болох дуслын усалгааны системийг ашиглаж байгаа ба усны зарцуулалт бага мөн усны ууршилт алдагдал хамгийн багатай арга юм.

Шувуудад хиймэл үүр хийж, байрлуулав

Хээрийн махчин шувууд идэш тэжээл элбэг ч байгалийн үүрлэх байр ховор байдгаас хамааран тэдгээрийн тоо толгой тогтвортой байх, өсөж үржих нөхцөл боломж хязгаарлагддаг. Мөн зарим төрлийн шувууд өөрсдөө үүр засдаггүй ба хад асга, модонд өөр төрлийн шувуудын зассан бэлэн үүрэнд үүрлэдэг. Ийм төрлийн шувууд сүүлийн жилүүдэд өндөр хүчдэл дээр сууж, цахилгаанд цохиулан олноор эрсдэх тохиолдол манай орны хэмжээнд гарах болсон. Тиймээс идэш тэжээл элбэг газар нь хиймэл үүр хийх нь шонхор, сар зэрэг хээрийн махчин шувуудын өсөлтөд ихээхэн ач холбогдолтой. Мөн түүнчлэн бэлчээрийн хөнөөлт мэрэгчдийн зохистой тоо толгойг хадгалахад махчин шувуудад зориулсан хиймэл үүр чухал хэрэгцээтэй юм.



Шувуудад зориулан хийсэн үүрний үзэгдэх байдал

Иймээс тайлант хугацаанд Ухаа Худаг уурхай орчмын бүс нутагт амьдарч байгаа өдрийн болон шөнийн идэвхит махчин шувуудыг хамгаалах зорилгоор тэдэнд зориулан шувууны хиймэл үүр хийж Ойн зурвас, Сэвхүүлийн хөндий, Цэций хайрханы өвөр, Хээрийн булаг зэрэг тодорхой газруудад суурилуулах ажлыг зохион байгуулсан.

Орчны тохижилтонд ашиглагдах мод, бут, сөөгийг туршилтын талбайгаасаа бэлтгэв

Биологийн нөхөн сэргээлтэнд зориулсан мод, бут, сөөг, нутгийн ургамал болон олон наст ургамлыг туршилтын журмаар ургуулан тухайн бүс нутагт зохицсон ургамлыг сонгон шалгаруулж улмаар үржүүлэн нөхөн сэргээлт болон орчны тохижилт, ойн зурвас байгуулах ажилд ашиглах зорилгоор 2009 онд 2.5 га талбайд байгаль орчны нөхөн сэргээлтийн туршилтын талбайг байгуулсан билээ.

Одоогоор тус талбайд 24 төрлийн 60.000 гаруй мод сөөг бутлаг ургамал ургаж байна.

Эдгээр мод сөөг, бутлаг ургамлыг үрээр болон мөчрөөр тарьсан бөгөөд 2013 онд Үндэсний мод тарих өдөр Хамгаалалтын ойн зурваст 10.600ш, Хаягдал чулуулгын овоолгын нөхөн сэргээлтэнд, 8.000ш, Цогтцэций сумын албан газруудад 1.808ш, орон нутгийн иргэдэд 4.500ш, Мөрөөдөл сургуулийн тохижилтонд 1.350ш болон цахилгаан станцын тохижилтонд 1.100 ш мод бут сөөгийг туршилтын талбайгаас бэлтгэн нийлүүлсэн.

ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ

Төслийн үйл ажиллагаанаас үүдэлтэй үүсч буй нийт хог хаягдлыг байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг нь бууруулах үүднээс системтэйгээр цуглуулж, зайлуулах нь хариуцлагатай уул уурхайн баримталдаг зарчмуудын нэг юм. Үйл ажиллагаа өргөжихийн хирээр хог хаягдлын үүсэх хэмжээ нэмэгдэж, цаг тухайд нь зохистойгоор зайлуулаагүйн улмаас орчны бохирдол ихсэх эрсдэл байдаг. Иймд байгаль орчны багийн зүгээс хог хаягдлын үүсэлтийг бууруулах, дахин ашиглах болон дахин боловсруулах, хаягдлыг ангилан ялгах, цуглуулах, зайлуулах ажлыг системтэйгээр зохион байгуулж хог хаягдлын менежмент төлөвлөгөөг улам боловсронгуй болгох тал дээр анхааран ажиллаж байна.

2013 оны хувьд төслийн барилгажилт дууссантай холбоотой хатуу хог хаягдлын хэмжээ 2012 онтой харьцуулахад 35 хувиар буурсан. Түүнчлэн жил бүр бид хог хаягдлын дахин ашиглалтын хэмжээг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллаж, бие даасан хөтөлбөрүүд, санал санаачлагыг хэрэгжүүлж ирсэн. Тухайлбал 2012 онд төслийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн Хог хаягдлын менежментийн 3R+R системийг боловсруулан хэрэгжүүлсэн бөгөөд тухайн хаягдлын дахин боловсруулах болон ашиглах арга технологийн сонголтоос шалтгаалан ангилан ялгалтыг хийж байна.

Мөн хаягдлын ангилан ялгалтыг хийхдээ хогийн савны өнгөний кодчлолын системийг нэвтрүүлж, хаягжуулж ашигласан нь хатуу хог хаягдлын хэмжээг өмнөх 2011 онтой харьцуулахад 11 хувиар бууруулж чадсан.

Хүснэгт 3. Хатуу хог хаягдал болон дахин ашиглалтын хэмжээ

	2010	2011	2012	2013
Хатуу хог, м³	6001	16040	22602	14520
Дахин ашиглалт [%]	50	59	70	71

2013 онд Ухаа Худаг уурхайн төслийн үйл ажиллагаанаас үүссэн дахин ашиглагдах болон дахин боловсруулагдах хаягдлыг бүтээгдэхүүн болгон эдийн засгийн эргэлтэнд оруулах үүднээс 2013 оны 10-р сард дахиварын цехийн үйл ажиллагааг эхлүүлсэн.



Дахиварын цехийн эцсийн бүтээгдэхүүн барилгын блок

Уг дахиварын цехийн үйл ажиллагааны хүрээнд дахин ашиглагдах болон дахин боловсруулагдах хаягдлаар бүтээгдэхүүн хийн зах зээлд нийлүүлж байна. Тухайлбал, Ухаа Худаг төслийн уурын зуухнуудаас гарах үнсийг ашиглан шаариган блок өдөрт 600 ширхэг үйлдвэрлэх хүчин чадалтай техник тоног төхөөрөмжийг суурилуулсан. Мөн төслийн үйл ажиллагааны хүрээнд үүсч буй төмрийн хаягдлыг ашиглан хогийн сав, зуух, хашаа, гүйдэг болон гүйдэггүй хаалга, малын хашаа, галын хайч болон сандал хийж байна.

Дахин ашиглагдах болон боловсруулагдах хаягдлыг ашиглан тус үйл ажиллагааг явуулж буй дахиварын цехийн байрыг барьж байгуулсан. Дахиварын цехийн байр нь ажилчдын амрах өрөө, гал тогоо, агуулах болон 144м² талбай бүхий цехийн байгууламжтай юм.



Дахиварын цехийн эцсийн бүтээгдэхүүн сандал

Төслийн үйл ажиллагаанаас үүсч байгаа хог хаягдлыг эх үүсвэрт нь болон хог хаягдал ангилан устгах цэг дээр төвлөрүүлж, ангилан ялгалт хийх бөгөөд дахин ашиглах боломжгүй хаягдлыг байгаль орчинд ээлтэйгээр зайлуулдаг. Хатуу хог хаягдал ангилан устгах цэг нь ангилан ялгах хэсэг, хуванцар, төмрийн болон бусад дахин ашиглагдах хог хаягдлыг цуглуулах хэсэг, бохирдсон хөрс цуглуулах талбайнуудад хуваагддаг. Дахин боловсруулагдах болон дахин ашиглагдах боломжгүй хаягдлыг зориулалтын шатаах зууханд шатааж овор хэмжээг багасгасны дараа хаягдал чулуулгын овоолгон доор булшилдаг.

Төслийн хүрээнд аюултай хог хаягдлын зохицуулалтыг хийхэд "Аюултай хог хаягдлын төлөвлөгөө" боловсруулан хэрэгжүүлж эхлээд байна. Уг төлөвлөгөөний гол зорилго нь хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд үзүүлэх хортой нөлөөллийг арилгах, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор ахуйн болон үйлдвэрлэлийн аюултай хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хадгалах, булах харилцааг зохицуулахад оршино.

Төслийн үйл ажиллагаанаас бохир ус болон хоолны хаягдал гэсэн хоёр төрлийн шингэн хаягдал гардаг. Нийт 396.1 тн хоолны үлдэгдэл үүссэнийг орон нутгийн гахайн аж ахуй эрхэлж буй иргэдэд өгсөн байна. Төслийн хэмжээнд 100м³ бохир усыг биологийн аргаар цэвэршүүлэх хүчин чадалтай цэвэрлэх байгууламж болон 1,200м³ бохир ус цэвэрлэх хүчин чадалтай Цогтцэций сумын цэвэрлэх байгууламжуудад нийт ахуйн хаягдал усыг цэвэрлэж, Монгол улсын цэвэрлэгдсэн бохир ус хөрсөнд хаях стандартад нийцүүлэн цэвэршүүлж байна. Цэвэрлэгдэн гарч буй уснаас сар бүр химийн болон бактериологийн дээжийг авч улсын итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлж байнгын хяналттай ажиллаж байна. Тайлант хугацаанд нийт 106,986 тн бохир усыг цэвэрлэж зам талбайн усалгаанд ашигласан.

УСНЫ ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭЭ

Ухаа Худаг уурхайн цогцолборын үйлдвэрлэлийн болон ахуйн хэрэглээний ус хангамжийн ухаалаг бөгөөд дэвшилтэт системийг бий болгох ажил 2008 оны 1-р сараас эхэлж улмаар 2011 оны 6-р сард ашиглалтад орсон. Ингэснээр уурхайн нийт төслүүдийн усны хэрэгцээг хангаад зогсохгүй Өмнөговь аймгийн Цогтцэций сумын иргэдийг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн, цэвэршүүлсэн ундны усаар хангаж байна. Ус хангамжийн систем нь 56,000м³ багтаамжтай усан сан, насос станц болон иж бүрэн автомат хяналтын систем гээд технологийн онцлог шийдэл бүхий хэсгүүдээс бүрдэл болдог. Усан сангаас ус шүүрч алдагдахаас сэргийлж ёроолыг бүрэн доторлосон бөгөөд ууршилтаас хамгаалах битүү хучилттай хийсэн.



Ухаа худаг төслийн ус хангамжийн систем

2013 онд ус хангамжийн системийн өргөтгөлийн ажлын хүрээнд Наймдайн хөндийн усны шугам хоолой, барилга угсралтын ажил үргэлжлэн хийгдсэн. Мөн Цогтцэций сумын төвд 1200 м³ хоног хүчин чадалтай ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжийг ашиглалтанд оруулсан.

Түүнчлэн 2013 оны 10-р сард уурхайн нүүрс баяжуулах үйлдвэрийн дэргэд Хаягдлыг усгүйжүүлэх үйлдвэрийг барьж байгуулснаар үйлдвэрийн хаягдлыг маш богино хугацаанд усгүй болгон, эргүүлэн Нүүрс баяжуулах үйлдвэрийн хэрэгцээний усыг нөхөх боломж бүрдэж, хаягдлаас ус буцаан гаргаж авч, үйлдвэрлэлд ашиглах усны хэмжээ өмнөхөөс дор хаяж 60–70% нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Булаг шанд, уст цэгүүдийн орчны хог хаягдлыг цэвэрлэж, хамгаалав

Энержи Ресурс ХХК-ийн Ухаа Худаг уурхайн 30 километрийн радиуст байгаа 3 булаг шанд, малчдын 13 гар худгууд орчмын 500м газрын хатуу хог хаягдлыг цэвэрлэж, нэг гар худгийг хамгаалах арга хэмжээ авлаа. Энэ ажлын хүрээнд 4 куб.метр орчим ахуйн хатуу хог хаягдлыг



Худгийн ойр орчмыг цэвэрлэж хамгаалах ажлын үеэр

цэвэрлэж, Цогтцэций сумын хатуу хог хаягдлын цэгт тээвэрлэн хүргэж хаясан. Уст цэгийг хамгаалах ажлын хүрээнд Цогтцэций сумын баруун хойно 1 км-т байрлах Хулсан ус худгийн хашилт хаалтыг сэргээж, 20 орчим хаягдал дугуйг ашиглан хамгаалалт хийсэн. Хамгаалалт хийх нь худгийн дэргэд машинтай очиж машин угаах, худгийн усыг бохирдуулах зэрэг явдлыг хязгаарлах ач холбогдолтой юм.

АГААРЫН ЧАНАР, ТООСЖИЛТ

2013 онд Ухаа Худаг төслийн үйл ажиллагаанаас үүдэлтэй үүсэх орчны агаарыг бохирдуулах хийнүүдийг тодорхойлох, үүсч болох эх үүсвэрүүдийг байнгын хяналтанд авах, тэдгээрийн хэмжээг стандарттай харьцуулж үзэх, зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн бол бууруулах арга хэмжээ авах зэрэг ажлуудыг хийж ажилласан.

Энэ ажлын хүрээнд 2013 оны 11-р сард “Ухаа Худаг төслийн хүрээнд агаар бохирдуулагч хийн ялгаралыг хянах, бууруулах менежмент төлөвлөгөө” –г анхлан боловсруулсан. Хийгдэж буй агаарын чанарын хяналт шинжилгээний ажлыг гадаад орчны агаарын чанарын хяналт шинжилгээ болон суурин эх үүсвэрээс ялгарч байгаа утааны хийн найрлагын хяналт шинжилгээ гэж ангилна. Агаарыг голлон бохирдуулдаг азотын ислүүд (NOx), хүхрийн давхар исэл (SO₂), нүүрстөрөгчийн дутуу исэл (CO), нүүрсхүчлийн хий (CO₂) зэрэг хийнүүдэд голлон анхаарч ажиллаж байна.

Ухаа худаг уурхайн үйл ажиллагааны явцад тоос үүсгэгч эх үүсвэрүүд нь уурхайн олборлолт, ачилт, тээвэрлэлт, хаягдал чулуу буулгах үйл ажиллагаанууд юм. Уурхайд тоос үүсгэж буй эх үүсвэрүүдийг тогтоож, зохих арга хэмжээг авч, мониторинг, туршилтыг “Уурхайн тоос бууруулах ажлын хэсэг” байгуулан ажиллаж байна.

Тоос бууруулах чиглэлээр хийгдэж буй ажил, үр дүн зэргийг нэгтгэн тайлан гаргаж Цогтцэций сумын ЗДТГ сар бүр хүргүүлдэг ба тоосны хэмжилтийн ажилд Цогтцэций сумын улсын байцаагч хяналт тавьж ажилладаг. Уурхайд үүсч буй тоосны эх үүсвэрүүдийг дараах 3 хэсэг байна гэж тодорхойлсон.

- Уурхайн олборлолт, ачилт, тээвэрлэлт
- Нүүрс ачиж буулгах талбай
- Нүүрс баяжуулах үйлдвэр

Уурхайн дотоод технологийн зам, хаягдал чулуулгийн овоолго, олборлолт явагдаж буй карьер гэсэн үндсэн 3 эх үүсвэрээс тоос үүсч байгааг илрүүлэн тоосны чөлөөт уналтыг 14 хоногт 1 удаагийн давтамжтайгаар хэмжихийн хамт агаар

дахь хатуу хэсгийн хэмжээг 7 хоногт 3 удаагийн давтамжтайгаар тогтмол хэмжсэн. Судалгааны үр дүнд үндэслэн туршилт хийснээр уурхайн технологийн замын тоосжилтыг тодорхой хувиар бууруулаад байна.

Уурхайн тоосжилтыг бууруулахын тулд дараах ажлыг хийсэн.

- Тоосны хэмжээг эх үүсвэр дээр нь хянах мониторингийн цэг байгуулсан
- Уурхайн олборлолтоос гардаг материалаас дээж авч итгэмжлэгдсэн лабораторид шинжилгээ хийлгэсэн
- Технологийн замд ашиглах боломжтой материалын сонголт хийсэн
- Замын материалыг өөрчилж туршсан
- Замын материалыг нөөцөлж эхэлсэн
- Уурхайн 50 тонны эзэлхүүнтэй усны машинаар үргэлжлүүлэн услах болон таслан услах байдлаар усалгаа хийсэн.
- Замын материалтай тоос бууруулах бодис хольж туршсан

БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭ

Энержи Ресурс ХХК нь байгаль орчны сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах зорилгоор төслийн үйл ажиллагаа явагдаж буй Цогтцэций, Ханхонгор, Ханбогд болон Баян-Овоо сумдын нутаг дэвсгэрийг хамарсан нийт 244 цэгт тодорхой давтамжтайгаар ус, агаар, хөрс, ургамал болон амьтны чиглэлээр мониторингийн ажил хийж гүйцэтгэдэг.

Мониторингийн ажлын төлөвлөгөө болох орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг жил бүр боловсруулж байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулан мөрдөж ажилладаг. Мөн байгаль орчны хяналт шинжилгээний ажил гүйцэтгэх тухай байгууллагын дотоод журмыг боловсруулан үйл ажиллагаандаа ашигладаг.

Компанийн байгаль орчны багийн мэргэжилтнүүд мониторингийн ажлыг хариуцан гүйцэтгэдэг бөгөөд хэргийн судалгааны хэмжилт дээжлэлтийг Монгол Улсын холбогдох стандартыг баримтлан, орчин үеийн багаж хэрэгсэл ашиглан гүйцэтгэж, дээж сорьцийг дотоодын болон гадаадын итгэмжлэгдсэн лабораториудад шинжлүүлдэг. Мөн компани иж бүрэн тоноглол бүхий орчны хяналт шинжилгээний лабораторитой бөгөөд одоогоор уг лабораторд усны хими, бактериологийн болон арчдасын шинжилгээ хийж гүйцэтгэн дотоодын хяналтыг хэрэгжүүлж байна. Компанийн байгаль орчны үйл ажиллагааг нээлттэй байлгах зорилгоор мониторингийн хэргийн хэмжилт судалгааны ажилд орон нутгийн

иргэдийг оролцуулах ажлыг зохион байгуулахаас гадна компаниас эрхлэн гаргадаг сар тутмын мэдээллийн хуудсанд мониторингийн хэмжилт судалгааны ажлыг тогтмол нийтэлдэг. Хэргийн хэмжилт судалгаа ба лабораторийн шинжилгээний үр дүнд бий болсон өгөгдөл мэдээг нэгтгэн мэдээллийн сан үүсгэн хадгалж ашигладаг.

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ (ХАБ)-ЫН БОДЛОГО ЦИГ, БАРИМЖАА

Компанийн ажиллагсадын аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудлыг чухалчлан үзэж, эрүүл аюулгүй ажиллах орчин бий болгох нь бидний эрхэм зорилго юм. Нийгмийн өмнө хүлээсэн хариуцлагаа ухамсарлан, нийт ажилтан ажиллагсадаа эрүүл аюулгүй орчинд ажиллуулахаас гадна, өөрийн үйл ажиллагааны хүрээнд оролцож буй бүх талуудын аюулгүй байдлыг хангаж ажилладаг.

Хайгуул, ашиглалт, тээвэрлэлт үйлдвэрлэл болон нөхөн сэргээлтийн бүхий л үе шатанд Энержи Ресурс ХХК нь ажиллагсад, гэрээт гүйцэтгэгч болон олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны шаардлагад нэн тэргүүний чухал ач холбогдол өгч “АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАСНЫ ДАРАА АЖЛАА ЭХЭЛЬЕ” хэмээх уриаг эрхэмлэн ажилладаг.

Энержи Ресурс компанийн Хөдөлмөрийн Аюулгүй Байдлын нэгж нь Ухаа Худаг төслийн хүрээнд Хөдөлмөрийн Аюулгүй Байдал Эрүүл Ахуйн Удирдлагын Тогтолцоо OHSAS 18001: 2007 тогтолцоог нэвтрүүлж, хэрэгжүүлж, хэвшүүлэхээр төлөвлөлт, баримт бичгийн боловсруулалт, бүрдүүлэлтийн шатандаа явж байна. 2013 онд ХАБ-ын үүрэг хариуцлагын матрицыг боловсруулсан нь компанийн ажилтан тус бүрийн эрүүл аюулгүй ажиллах орчин бий болгоход тэдний үүрэг оролцоог тодорхойлж, ажилтан тус бүрийн ажлын байрны тодорхойлолтонд тусгаж өгсөн.



Аюулгүй байдлыг хангасны дараа ажлаа эхэлье

Хүснэгт 4. ХАБ-ын гол үзүүлэлтүүд

ХАБ-ЫН ҮЗҮҮЛЭЛТ	2011	2012	2013
Нийт ажилласан хүн цаг	9,478,601	8,380,412	8,154,576
Эндэгдэл	0	1	1
Нийт гэмтлийн давамж	4.77	3.94	3.56
Хугацаа алдсан гэмтлийн давамж (LTIFs)	1.67	0.72	1.23
Хууль, журамд нийцэж ажилласан байдал	100%	94%	Хяналт шалгалт ирээгүй
Алдсан хоногийн давамж (ажиллаагүй хоног/ажилласан цаг)	0.000034	0.000019	0.000028
ХАБ-ын сургалт, зааварчилгаа (ажиллагсад болон гэрээт гүйцэтгэгч)	5,403	6,783	12,881

ХАБ-ЫН СУРГАЛТ, ЗААВАРЧИЛГАА

Ажлын байрны эрсдлийн үнэлгээ хийх, хөдөлмөрийн нөхцлийг тодорхойлох, нийт ажиллагсдад хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сургалтыг зохион байгуулах, ажлын байрны үзлэгийг тогтмол хийж зөрчлийг арилгуулах, ослын судалгааг хийх гэх мэт ажлууд тогтмол хийгддэг. 2013 оны хувьд нийт 94 ажлын байрны аюулгүйн үзлэг зохион байгуулж илэрсэн дутагдал зөрчлийг арилгах шаардлагатай бүхий л арга хэмжээг авч ажилласан. Хөдөлмөрийн аюулгүй байдлын доорх сургалтууд 2013 онд хийгдсэн.



Хүснэгт 5. ХАБ-ын сургалт

СУРГАЛТ, ЗААВАРЧИЛГАА	НИЙТ ХҮН ЦАГ
Шинээр ажилд орж байгаа ажилтны сургалт (ерөнхий аюулгүй ажиллагааны сургалт)	4445 * 8.5 (хүн/цаг) = 37783
Зочдод зориулсан зааварчилгаа	3619 * 0.2 / 20min (хүн/цаг) = 724
Давтан сургалт	3800 * 3 (хүн/цаг) = 11400
Мастеруудад зориулсан сургалт	50 * 2 (хүн/цаг) = 100
Эрсдлийн үнэлгээ	40 * 2 (хүн/цаг) = 80
Үйлдвэрлэлийн аюул ослоос урьдчилан сэргийлэх үндсэн асуудал	70 * 2 (хүн/цаг) = 140
Жолоочийн аюулгүй ажиллагааны сургалт	300 * 2 (хүн/цаг) = 600
Ядаргааны менежмент	80 * 2 (хүн/цаг) = 160
Нүүрсний хатуу хучилттай зам ашиглалтын журам	80 * 2 (хүн/цаг) = 160
Замын хөдөлгөөний дүрэм журам, аюулгүй ажиллагаа	200 * 2 (хүн/цаг) = 400
Ээлж солигдох үеийн сургалт	100 * 2 (хүн/цаг) = 200
Аюулгүй ажиллагааны хандлага	80 * 2 (хүн/цаг) = 160
ХАБ-ын ажлын онцлог хүндрэлүүд, арилгах арга замууд	17 * 2 (хүн/цаг) = 34

Мөн түүнчлэн компанийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн бодлого, Ухаа Худаг төслийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн систем, хамгаалах хэрэгслийг ашиглах, цахилгааны аюулгүй ажиллагаа, онцгой нөхцөл байдлын журмууд, ослын менежмент, эрсдлийн менежмент болон анхны тусламжийн сургалтууд тогтмол хийгддэг.

АЖИЛЛАГСДЫН ЭРҮҮЛ МЭНД

Ажиллагсдын эрүүл мэндэд учирч болзошгүй эрсдлийг судалж ойлгон тэдгээрийг хянаж, бууруулах шат дараатай арга хэмжээ авч ажиллах нь компанийн БОХАБЭА-ын бодлогын чухал хэсэг юм. Уул уурхайн салбарын хувьд үүсч болох мэргэжлийн онцлогоос хамаарсан гол өвчлөл нь ажлын ядаргаа, стресс, булчин болон ясны гэмтэл бэртэл, дуу чимээнээс гаралтай дүлийрэл, тоосжилтоос үүдэлтэй амьсгалын замын өвчин болон халдварт өвчин багтдаг. Компанийн эрүүл ахуйн бодлогын хүрээнд бид ажлын байрны үзлэгийг тогтмол зохион байгуулж, ажиллагсдын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж болох ажлын байруудыг тодорхойлж, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зохих арга хэмжээг авдаг.

Мөн дотоод сургалтаар дамжуулан гэмтэл бэртэл болон бусад өвчлөлөөс өөрийгөө хамгаалах тухай сургалтууд болон мэдлэг ойлголт өгөх кампанит ажлууд хийгддэг. Уурхайн сайт дээр долоо хоногийн 24 цагийн турш бүрэн бэлтгэлтэй эмнэлэг, эрүүл ахуй, яаралтай тусламжийн баг ажиллаж, ажиллагсдад эрүүл мэндийн тусламжийг үзүүлж ажилладаг.

ТҮҮХЭН ТОВЧООН



● 2008 оны 8-р сар.

Эзгүй хээр талын дунд Ухаа Худаг хотхон байгуулагдав.



● 2008 оны 12-р сар.

Уурхайн үйл ажиллагааг эхлэхээс өмнө нутгийн иргэд, малчдад төслийн үйл ажиллагааг танилцуулж, мэдээллээр ханган, санал солилцох үүднээс анхны нээлттэй өдөрлөг хэлэлцүүлгийг Цогтцэций, Ханбогд, Баян-Овоо сумын иргэдийг хамруулан зохион байгуулав.



● 2009 оны 4-р сар.

Ухаа Худаг уурхайг улсын комисс хүлээн авснаар олборлолтын үйл ажиллагаа эхлэв.



● 2009 оны 8-р сар.

Тавантолгой нисэх буудал ашиглалтад орлоо.



● 2010 оны 6-р сар.

Орчин үеийн шинэлэг дизайн, архитектурын онцгой шийдэл бүхий Галерей кэмп ашиглалтад оров.



● 2010 оны 6-р сар.

Нэг дор хүнд даацын 5-7 техникт засвар үйлчилгээ үзүүлэх хүчин чадалтай засварын төв ашиглалтад оров.

● 2010 оны 11 сар.

"Mongolian Mining Corporation" нэрээр Хонконгийн Хөрөнгийн биржид бүртгүүлж, Монголын компаниудаас анх удаа олон улсын хөрөнгийн зах зээлд хувьцаагаа гаргав.



● 2011 оны 3-р сар.

Уурхайн ажиллагсдын "Цэций" орон сууцны хорооллын эхний ээлжийн барилгууд ашиглалтад оров. Өдгөө "Цэций" хорооллын цар хүрээ улам бүр өргөжиж, 1 ба 2-р ээлжийн барилгууд ашиглалтад орсон ба нийт 300 орчим өрх бүрэн тавилгатай, тохилог орон сууцанд ороод байна.



2011 оны 10-р сар.

Ухаа Худаг – Гашуунсухайт чиглэлийн 245 км, үйлдвэрийн зориулалтын хатуу хучилттай авто зам ашиглалтад орж, нүүрс тээвэрлэлтийн аюулгүй байдлыг дээшлүүлж, нутгийн байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулахад чухал алхам хийгдэв.



2011 оны 6-р сар.

Монголын анхны Нүүрс баяжуулах үйлдвэрийн эхний модуль ашиглалтад орсноор дотооддоо нүүрсэнд нэмүү өртөг шингээж, дэлхийн зах зээлд монгол нүүрсний үнэ цэнийг нэмэгдүүлэхэд чухал алхам хийгдэв. Тус үйлдвэрийн 2 ба 3-р модуль 2012 оны 2-р сар ба 2013 оны 6-р сард тус тус ашиглалтад орсон.

2011 оны 6-р сар.

Ус хангамжийн дэвшилтэт систем ашиглалтад орж, уурхайн цогцолборын үйлдвэрлэлийн болон ахуйн усны хэрэгцээг хангаад зогсохгүй Цогтцэций сумыг ундны цэвэршүүлсэн усаар хангаж эхлэв.

2011 оны 9-р сар.

Монгол инженерүүдийн ур ухаан, хамтын хөдөлмөрөөр бүтсэн, 18 мегаваттын цахилгаан станц ашиглалтад орж, уурхайн цогцолбор төдийгүй Цогтцэций сумыг байнгын эрчим хүчээр хангаж эхлэв.



2012 оны 1-р сар.

Төрийн өмчит Эрдэнэс-МГЛ компанитай хамтран Гашуунсухайтын хилийн боомтод өргөтгөл хийж, нэвтрүүлэх хүчин чадлыг өмнөхөөс 2-3 дахин нэмэгдүүлэв.

2012 оны 10-р сар.

Нэг дор хүнд даацын 5 автомашинд засвар үйлчилгээ үзүүлэх чадалтай орчин үеийн засварын төв ашиглалтад орж, тээвэрлэлтийн найдвартай, аюулгүй байдлыг хангахад чухал ахиц гарав.

2013 оны 1-р сар.

Орчин үеийн боловсролын стандартыг бүрэн хангасан "Мөрөөдөл" сургууль, цэцэрлэгийн цогцолбор (700 хүүхдийн сургууль, 144 хүүхдийн цэцэрлэг, 100 хүүхдийн дотуур байр)-ыг Өмнөговь аймгийн ЗДТГ-тай хамтран байгуулж, алслагдмал орон нутгийн боловсролын чанарт томоохон ахиц дэвшлийг бий болгов.

2013 оны 10-р сар.

Нийт 3 модуль бүхий Нүүрс баяжуулах үйлдвэрийн дэргэд Хаягдлыг усгүйжүүлэх үйлдвэрийг шинээр барьж ашиглалтад оруулснаар үйлдвэрлэлд ашиглагдах усны хэмжээг өмнөхөөс 60-70% нэмэгдүүлж, байгаль орчинд ээлтэй, орчин үеийн шилдэг технологийг Монголд нутагшуулав.

БИДНИЙ АМЖИЛТ, ҮР ДҮН

Зүүн өмнөд Азийн Филиппин улсад зохион байгуулагдсан “Global CSR Award-2013” хэмээх нэр хүнд бүхий КНХ-ийн олон улсын шагнал гардуулах арга хэмжээнээс Энержи Ресурс ХХК нь Ажлын байрны тав тухтай нөхцөл бүрдүүлсэн шилдэг компани номинацад өрсөлдөн мөнгөн буюу дэд байранд шалгарсан. Мөн тус компанийг Өмнөговь аймгийн Барилгын инженерүүдийн Холбооноос 2013 оны “Барилгын салбарын шилдэг хөрөнгө оруулагч аж ахуйн нэгж”-ээр тодруулж, “Мөрөөдөл” цогцолборыг шилдэг барилгаар нэрлэсэн.

Энержи Ресурс компани нь Монголын Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас жил бүр тодруулдаг улсын TOP 10 аж ахуйн нэгжийн нэгээр 5 жил дараалан шалгарсан бөгөөд “Coal Mongolia 2013” олон улсын чуулга уулзалтаар улсын TOP 3 нүүрс үйлдвэрлэгчийн нэгээр нэрлэгдсэн.

Мөн 2013 оны 12-р сарын 17-нд Монгол Улсын Засгийн газрын дэргэдэх Усны үндэсний хороо, Монголын усны түншлэл ТББ-аас Энержи Ресурс ХХК-ийг 2013 оны “Усны салбарын шилдэг хөрөнгө оруулагч”-аар шалгаруулж, батламж олгосон. Энэхүү шагналыг УИХ-аар батлагдан хэрэгжиж буй “Ус” үндэсний хөтөлбөр болон Шинэчлэлийн Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, Монгол орны усны нөөцийг зүй зохистой ашиглах, хамгаалах, усны салбарт орчин үеийн дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэхэд бодитой хөрөнгө оруулсныг үнэлэн олгож буйг зохион байгуулагчдын зүгээс онцолсон байна.

2013 он дан ганц нүүрсний салбар гэлтгүй уул уурхайн салбарын хувьд амаргүй, хүндхэн жил байсан боловч Энержи Ресурс компанийн зүгээс бүтээмжээ нэмэгдүүлэх, зардал бууруулах, үйл ажиллагааны оновчтой зохион байгуулалтад шилжих зэргээр дотоод нөөц бололцоогоо дайчлан ажилласны үр дүнд өмнөө тавьсан зорилго, зорилтуудаа бүрэн гүйцэд биелүүлсэн.

Тайлант онд тус компани нь нийгмийн хариуцлагын бодлогын хүрээнд Өмнөговь аймгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд бодит хувь нэмэр оруулж, орон нутгийн иргэд, засаг захиргаа, олон нийттэй сайн хөршийн харилцаагаа үргэлжлүүлэн, хариуцлагатай уул уурхайн зарчмуудыг ханган ажиллалаа.

Олон улсын зах зээлд нүүрсний нийлүүлэлт эрэлтээсээ давсны улмаас 2012 оны 2-р улирлаас хойш нүүрсний үнэ тасралтгүй унаж, өнөөдрийг хүртэл зах зээлийн байдал таагүй байгаа хэдий ч тус компанийн хувьд сүүлийн 5-6 жилийн хугацаанд оруулсан хөрөнгө оруулалт, байгуулсан үйлдвэр, дэд бүтцийнхээ үр өгөөжийг гаргахын төлөө хичээж ажиллаж байна.

Энержи Ресурс компани нь цаашид орон нутгийн өөрөө удирдах байгууллага, иргэд, малчид, бизнес эрхлэгчид зэрэг оролцогч талуудтай хамтран ажиллаж, аймаг орон нутаг болон улс орныхоо бүтээн байгуулалт, хөгжил цэцэглэлтэнд хувь нэмрээ оруулан ажилласаар байх болно.





Хаяг: Сэнтрал Тауэр, 16 давхар
Сүхбаатар дүүрэг
Улаанбаатар хот 14200
Монгол Улс

Утас: + (976)–70122279, 70132279
Факс: + (976)–11–322279
Цахим шуудан: contact@energyresources.mn
Цахим хаяг: www.energyresources.mn

Ухаа Худаг Уурхайчдын хотхон
Ухаа Худаг, Цогтэций сум
Өмнөговь аймаг 46040
Монгол Улс
Утас: + (976)–77202279
Цахим шуудан: contact@energyresources.mn
Цахим хаяг: www.energyresources.mn